

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.12.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2019 оны 11 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд хуралдаж Баянгол, Мандал сумдад аймгийн ИТХ-аас батлан гаргасан тогтоол, шийдвэр, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сонсож, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажил, зарим төсвийн байгууллагуудын ажил байдалтай танилцаж, иргэдтэй уулзаж санал хүсэлтийг нь сонслоо.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 11 дүгээр сарын 9-өөс 15-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотод айлчлан хөдөө аж ахуйн бүхий л салбарт хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.11.15-ны өдрийн хурлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 17 дугаар хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр товлон хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоолоо.Үүнд:

- 1.Аймгийн 2020 оны төсвийн төсөл батлах тухай
- 2.Байгалийн ургамал түүж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай
- 3.Аймгийн хөгжлийг төлөвлөх загварчлал боловсруулах ажлын явц байдлын талаарх мэдээлэл
- 4.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 138 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Мөн энэ хурлаар хөдөө аж ахуй, газар тариалан, боловсролын салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 46 иргэнийг төрийн одон, медалиар, Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Ерөө сумын ахмад настан, ахмад тариаланч Даваасамбуугийн Пүрэвсүрэнг Монгол Улсын “Гавъяат агрономич” цол, Цагааннуур сумын Аханы Көкөнайг “Гавъяат эдийн засагч” цолоор, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Шивээбулаг ХХК-ны захирал Лувсанбатын Жаргалсайханыг Хөдөө аж ахуйн “Гавъяат механикжуулагч” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар сарын 12,16,17, 22-нд бүх сумдын нутгаар 0,0-2,0 мм, 4,10,11,13,21-нд зарим сумдын нутгаар 0,0-2,0 мм цас орсон. Бусад хугацаанд цас ороогүй, Салхи ихэнх хугацаанд салхи баруун болон баруун хойноос секундэд 4-9 метр байв. 4,10,12,16,17-нд салхи түр зуур ширүүсч секундэд 10-15 метр хүрч ширүүссэн, агаарын температур шөнөдөө 12-ныг хүртэл 6-11 градус хүйтэн, 13-наас 24-29 градус хүйтэн, өдөртөө 10-ныг хүртэл 5-10 градус дулаан, 11-нээс хүйтэрч 6-11 градус хүйтэн, 17,18,20-ны өдрүүдэд агаарын температур өдөртөө 13-18 градус хүйтэн, нийт сумдын нутгаар 1-10 см цасан бүрхүүлтэй хамгийн зузаан цасан бүрхүүл Хүдэр суманд 10 см, цасны нягт нь 0,13 г/см³ байна.

Аймгийн хэмжээнд энэ онд төмс 2471 га талбайгаас 33,5 мянган тонн, хүнсний ногоо 2481 га талбайгаас 29,0 мянган тонн, үр тариа 131,9 мянган га талбайгаас 164,2 мянган тонныг хураан авсан.

Энэ жил аймгийн хэмжээнд 17 сумын 56 багт 8896 малчин болон мал бүхий өрхөд 1,5 сая толгой мал өвөлжихөөр зохион байгуулалтын арга хэмжээг аваад байна. Хадлан бэлтгэх ажилд аймгийн хэмжээгээр механикжсан салаа 45, хадлангийн бага оврын тракторын иж бүрдэл 450, ажиллах хүч 3200 ажиллаж, 142,1 мянган тонн байгалийн хадлан, 37,9 мянган тонн хүчит тэжээл, 9,4 мянган тонн эрдэс тэжээл бэлтгэхээс 157,7 мянган тонн өвс, 4,5 мянган тонн сүрэл, 10,3 мянган тонн ногоон тэжээл, 26,4 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 6,6 мянган тонн дарш, 8,0 мянган тонн эрдэс тэжээл, 591 тонн гар тэжээл бэлтгэсэн нь мал бүхий иргэдийн түвшинд бэлтгэх өвс, тэжээлийг 104,1 хувьтай бэлтгэсэн байна.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 200 тонн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс 200 тонн өвс, 30 тонн хүчит тэжээл бэлтгэж 100 хувьтай, сумын нөөцөд 1700 тонн өвс, 510 тонн тэжээл бэлтгэхээс 1176 тонн өвс буюу 69.1 хувь, 375 тонн тэжээл буюу 73,6 хувьтай бэлтгэгдсэн дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд төв суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 07 тоот албан даалгаварыг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумдын халаалтын төвүүдийн үйл ажиллагаа жигдэрсэн хэвийн явагдаж байгаа бөгөөд нийт сумдын халаалтын төвүүд дунджаар 15-30 хоногийн түлшний өөцтэй байна.

Хот суурин газрын Цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга инженерийн шугам сүлжээний засварын ажил дуусч өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдсан, “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-аас Арангатын даваан дээр 8 хүний бүрэлдэхүүнтэй 3 төрлийн машин механизмтай шуурхай хэсэг байрлуулж, /автогрейдер-1, автосамосвал-1, үйлчилгээний машин-1/ бэлэн байдлыг хангасан. Өвлийн онцгой нөхцөлд зам даваан дээр хэрэглэх хуурай дайрга шороо 300 мЗ, давс, цас хайлуулах бодис зэргийг нөөцөлж, Ерөөгийн даваа, Арангатын даваанд байршуулсан.

Монгол Улсад атар газрыг эзэмшсэний 60 жилийн ойд зориулан “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлийн тусгай дугаарыг бэлтгэн гаргалаа. Энэхүү тусгай дугаарт 17 сумын газар тариалангийн салбараас төрөн гарсан алдартан гавьяатнуудын танилцуулга, Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн хүрээнд орон нутагтаа зохион байгуулсан ажил арга хэмжээ, сум тус бүрийн 1-2 хүний дурсамж дурдатгал, ярилцлага, аймаг орон нутагт зохион байгуулагдсан ажил арга хэмжээний талаарх мэдээ мэдээлэл багтсан. Мөн ойд зориулан зурагт альбомыг бэлтгэн гаргаад байна.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын дагуу боловсруулсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын албаны 5, Засаг даргын Тамгын газрын 31, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 11, Боловсрол, соёл урлагийн газрын 16, Орон нутгийн өмчийн газрын 4, Санхүүгийн хяналт, аудитын албаны 2, Хүнс, хөдөө аж ахуйн газрын 13, Эрүүл мэндийн газрын 23, нийт 8 байгууллагын 148 албан тушаалд хамаарах 105 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 11 дүгээр сарын 04-ний хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан шинэчлэгдсэн журмын дагуу зохион байгуулж, Ерөнхий шалгалтад бүртгүүлсэн 249 иргэнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын их танхимд 6 ээлжээр зохион байгуулж, ерөнхий мэдлэгийн сорилын шалгалтад 249 иргэн бүртгүүлснээс 219 иргэн оролцож 57 иргэн 35 ба түүнээс дээш оноо авч тэнцсэн, монгол хэл бичгийн чадварын шалгалтанд 57 иргэн орох

байснаас 56 иргэн оролцож 54 иргэн 20 ба түүнээс дээш оноо авч тэнцсэн, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад 54 иргэн оролцож 40 иргэн 10 ба түүнээс дээш оноо авч тэнцсэн. Тайланг төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчийн тагараг өргөх ёслолын арга хэмжээг 11-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Энэ онд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, албадын болон сумдын Засаг даргын Тамгын газрын 40 албан хаагч тангарагаа өргөлөө.

“Эрүүл, аюулгүй хөдөлмөрийн төлөө” аймгийн чуулганыг онол, дадлагыг хослуулсан зохион байгууллаа. Чуулганд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч, Монголын ажил олгогч эздийн Нэгдсэн холбоо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдах хүмүүс оролцон мэргэшил, арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч, сум, тосгодын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүд, аж ахуйн нэгж байгууллагын нийт 400 гаруй мэргэжилтэн албан хаагчид хамрагдсан.

Аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр 2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дүгнэн ярилцаж, 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө баталлаа.

Аймгийн Засаг даргын нэрэмжит 17 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн албан хаагчдын дунд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, олс таталт, шатар, усан спорт, ажлын байрны дасгал гэсэн спортын 7 төрлийн тэмцээнийг зохион байгууллаа. Энэ удаагийн тэмцээний нэг онцлог нь усан спорт, ажлын байрны дасгалын төрлийг нэмэгдэж орсон нь онцлог болсон. Тэмцээний багийн нийлбэр дүнгээр 1-р байранд Мандал сумын баг тамирчид, 2-р байранд Сайхан сумын баг тамирчид, 3-р байранд Сүхбаатар багийн баг тамирчид, 4-р байранд Ерөө сумын баг тамирчид шалгарсан.

Мэргэжлийн хяналтын газрын ажил үйлчилгээний талаар

Тайлант сард аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цагдаагийн газартай хамтран Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/556 тоот тушаалаар баталсан хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх “Хяналт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хамтарсан хяналт шалгалтыг ой бүхий сумдад хийлээ. Энэ хүрээнд Алтанбулаг суманд хууль бусаар мод бэлтгэсэн 5 зөрчлийг илрүүлэн холбогдох дүгнэлтийг гаргаж ажиллалаа.

Мөн аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран Сайхан, Хүдэр, Ерөө, Шаамар, Мандал, Сүхбаатар сумдад үйл ажиллагаа явуулж, гадаад иргэд ажиллуулж буй боловсрол, нийгэм, уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах” журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, дээрх аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 01/270 дугаар удирдамжийн хүрээнд МХЕГ-ын Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагчтай хамтран аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал суман дахь Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын Сум дундын эмнэлэгүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах зорилгоор улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлагыг өгч, биелэлтийг нь 2020 оны 02 дугаар сард гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж тооцохоор шийдвэрлэн ажиллалаа.

Сүхбаатар сумын 3 дугаарт багт байрлах 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга байгууламжийн ажлын зурагт урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, улсын байцаагчийн дүгнэлтийг гаргаж холбогдох байгууллагат хүргүүлээ.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 01/14 дугаар удирдамж, Аймгийн Засаг даргын 2019 оны А/25 тоот захирамжийн дагуу “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяны хүрээнд давсны хэрэглээг бууруулах чиглэлээр оролцох санал өгсөн 38 аж ахуйн нэгж, байгууллагын сонгосон бүтээгдэхүүнээс давсны агууламжийг тодорхойлох 95 дээжийг авч аймгийн

Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулаад байна. Мөн газрын даргын 18/42 дугаар удирдамжийн дагуу Сүхбаатар сумын “Борх-Арвижих” ХХК-ийн “Сэлэнгэ-Ундрах” цэвэр усны цехийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах хүртэл үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан.

Энэ оны ургацаас ТЭДС-ийн Хөтөл, Сэлэнгэ салбар, “Алтан тариа” ХХК, “Од групп” ХХК, “Спирт бал бурам” ХХК-ий хүлээн авсан хүнсний улаан буудай байдалд МХЕГ-ын даргын 01/243 тоот удирдамжийн хүрээнд хяналт шинжилгээ хийхэд хүнсний улаан буудайн чанар дунджаар цавуулаг 26.5 хувь, эзлэхүүн жин 743, тарианы хольц 9.7, гадны хольц 2.22 хувийн үзүүлэлттэй байна. Мөн 2020 оны хавар тариалах үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор хүсэлт өгсөн 10 аж ахуйн нэгж, иргэдийн үрийн буудайн чанар аюулгүй байдалд МХЕГ-ын Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын улсын ахлах байцаагчтай хамтран хяналт шинжилгээ хийж, ТЭДС-ийн Хөтөл салбарт 3 аж ахуйн нэгжийн 838 тонн улаан буудайн үрийн нөөц бүрдүүлэн ажиллаж, хяналт шинжилгээний дүн, танилцуулгыг хүргүүлэн ажиллалаа.

Шилэн хяналтын цахим системд 2018 онд 5403 объектод, 2019 онд 5602 объектод эрсдэлийн үнэлгээг хийж өмнөх жилээс 3,68 хувиар өссөн дүнтэй байна.

2019 оны 11 дүгээр сарын 25-ний байдлаар зөрчлийн 4 хэрэг нээж хуулийн хугацаанд нь аймгийн прокурорын хяналтандор бүрэн шийдвэрлэн ажиллалаа.

Нийт 57аж ахуйн нэгжийн 112 дээжинд 379 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 26 аж ахуйн нэгжийн 36 дээжийг 70 үзүүлэлтээр буюу шинжилэхэд 32.14 хувь нь эерэг гарлаа.

БНХАУ-д гахайн мялзан өвчин гарсантай холбогдуулан Сэлэнгэ аймагт гахайн мах, өөх, гахайн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болон гахайн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд сэрэмжүүлэг болгох, тус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/675 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газар, Худалдаа Аж Үйлдвэрийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Сэлэнгэ аймаг дахь салбар, Ажил олгогч эздийн холбоо, Шударга Өрсөлдөөн Хэрэглэгчдийн төлөө газрын Сэлэнгэ аймаг дахь салбар-тай хамтран “Төрийн хяналт-Бизнес эрхлэгч” уулзалт, ярилцлагийг нийт 250 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа. Уулзалт ярилцлагаар Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, хамтран ажиллах ажлыг зохион байгуулсан.

Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын цахим хуудсаар 11 удаагийн зөвлөмж сэрэмжүүлэг, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Тайлант сард Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр Хушаат, Сайхан, Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул, Алтанбулаг, Сүхбаатар, Баянгол, Мандал, Шаамар, Түшиг, Цагааннуур, Ерөө сумын нийт 14 аж ахуйн нэгж, иргэний 65 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 5 минимаркет, 41 хүнсний дэлгүүр, 3 хүнсний мухлаг, 3 зоогийн газар, 4 кафе, 3 караоке баар, 2 дэн буудал, 4 үсчний газарт тохирлын гэрчилгээ олгож, Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг 8 үсчний салбар, 4 гоо сайхны салбар, цэгүүдэд тохирлын үнэлгээ хийж, “Үс засах үйлчилгээ MNS 5160:2002”, “Гоёлын гоо заслын үйлчилгээ MNS 5567:2006” стандартаар хангаж, стандартын дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

Мөн Сайхан сумын “Ган зоо тур” ХХК-ийн үйлдвэрлэсэн “Толбот арзаахай” нэрийн эрүүл мэндийн цайны сав баглаа боодол, хаяг шошгыг стандартын шаардлага хангасан зөв мэдээллээр хангаж арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Стандартын салбар сангаас 29 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 23 нэрийн 52 стандартын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 13 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 15 нэрийн 25 стандартын борлуулалт хийсэн.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ, эзлэхүүн хэмжлийн төрлөөр Цагааннуур, Шаамар, Зүүнбүрэн, Мандал, Баянгол сумдад ажиллаж байгаа 17 шатахуун түгээх газрууд болон 79 хэмжих хэрэгсэлд ээлжит баталгаажуулалт, механик хэмжлийн төрлөөр Цагааннуур, Баянгол, Мандал, Шаамар сумдын эмнэлгийн болон худалдааны газрын нийт 153 жинг шалган баталгаажуулсан.

Цахилгааны хэмжлийн төрлөөр 2019 оны гэрээний дагуу Мандал суманд “ДСЦТС” ХК-ний лабораторитой хамтран 1 фазын 454 цахилгааны тоолуур, 1 фазын 1793 электрон тоолуурыг баталгаажуулалтад хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна. Өнгөрсөн сард 17592 баримтаар 75.1 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэсэн. Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулж байгаа бөгөөд 11-р сард Алтанбулаг, Хүдэр, Түшиг сумдад хийлээ.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		64.390.276.3	64.212.441.7	99.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	16.187.788.7	16.924.433.3	104.6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12.009.780.5	10.386.971.4	103.1
	Сумдын төсвийн орлого	4.178.008.2	4.537.461.9	108.6
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4.498.427.7	4.498.427.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	37.253.746.7	37.253.746.7	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	4.800.258.6	4.489.062.1	93.5
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/			
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	156.370.6	161.634.1	103.4
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	1.361.858.1	753.311.8	55.3
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		79.341.357.4	71.004.418.7	89.5
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	79.341.357.4	71.004.418.7	89.5
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	57.081.997.8	50.876.003.5	89.1
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2.071.237.1	1.464.181.2	70.7
	Сумдын сум хөгжүүлэх сан	1.112.640.8	265.932.0	23.9
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	21.529.006.8	19.415.684.8	90.2
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	600.000.0	554.652.7	92.4
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	549.000.0	161.656.8	29.4
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2.331.624.5	2.000.357.9	85.8
	Халамжийн сан	262.175.0	174.970.0	66.7
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	17.730.582.3	16.207.467.1	91.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	317.800.0	316.580.3	99.6
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	41.442.461.3	38.613.794.4	93.2
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	730.352.8	712.730.5	97.6

3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		48.320.398.8	48.320.398.8	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	10.948.867.1	10.948.867.1	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2.245.268.5	2.231.750.4	99.4
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	117.785.0	117.785.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	2.127.483.5	2.113.965.4	99.4
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2.672.775.1	2.231.750.4	83.5
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1.980.551.8	1.890.599.8	95.5
	Усны татаас	21.650.6	21.650.6	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	319.500.0	319.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	36.578.737.0	36.578.737.0	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	675.009.7	675.009.7	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	37.381.878.2	37.253.746.7	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	20.190.398.5	20.062.779.5	99.4
	- Хүүхдийн цэцэрлэг	10.814.280.3	10.813.767.8	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	5.596.839.1	5.596.839.1	100.0
	- Газрын кадастрын байгууллага	388.129.5	388.129.5	100.0
	- Хүүхдийн байгууллага	392.230.8	392.230.8	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.361.858.1	753.311.8	55.3

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 10- сар	2019 10- сар	<u>2019- 10</u> <u>2018-10</u> Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
Хонины мах /кг/	5 500	7 800	141.8
Үхрийн мах /кг/	6 500	8 500	130.8
Адууны мах /кг/	5 800	7 000	120.7
Ямааны мах /кг/	5500	6 500	127.3
Дотор мах, цувдай /цусгүй/	3000	4 000	133.3
Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
Сүү /задгай, л/	900	1 000	111.1
Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
Тараг /задгай, л/	1 200	1 300	108.3
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	15 000	115.4
Айраг /л/	3 500	3 500	100.0
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
Өндөг /ш/	350	350	100.0
4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			

	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	800	125.0
	Лууван /кг/	1000	1 100	110.0
	Манжин /кг/	1000	1500	150.0
	Байцаа /кг/	1000	1200	120.0
	Сонгино /кг/	1200	1500	125.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 800	121.7
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 750	106.4
	Бензин А - 92	1 795	1 840	102.5
	Дизелийн түлш	2 105	2 370	112.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн 2542 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 917 буюу 36 хувийг гэмт хэргийн шинжтэй, 1625 буюу 63,9 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 10 сард 446 холбогдогчтой 1918.4 сая төгрөгийн хохиролтой, 664 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 12 хэргээр буюу 1.8 хувиар өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 49.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,3 хувиар өссөн байна. Нийт 23129 зөрчил илрүүлсэн нь 3940 зөрчлөөр буюу 20.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Архивын баримтанд нягтлан шалгалт хийх ажлын хүрээнд аймгийн Банкны конторын хөмрөгийн 1964-2002 оны 175 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн тооллогохийж иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж устгах хэргийн акт, дансны шинэчилсэн бүртгэлийг боловсруулсан. Мөн хөмрөгийн 61 ХН-ийг байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу устгах хэргийн жагсаалт үйлдэж БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Мөн 61 хөмрөг болох Барилга угсралтын трестийн 1959-1990 оны 87 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн тооллого хийсэн.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Шаамар сумын ЗДТГ, Биеийн тамир спортын газар, Усны аж ахуйн удирдах газар, Цагаантолгойн САА-н хөмрөгийн 72 хадгаламжийн нэгжийн 7100 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж заалт 5883, хүний нэр 29309, байгууллагын нэр 2238, газар зүйн нэр 1559-г шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Биеийн тамир спортын газар, Арилжааны банкуудын хөмрөгийн 40 хадгаламжийн нэгжийн 3280 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэн хард болон DVD дээр хуулж, нөөц болон ашиглалтын хувь үүсгэсэн.

Иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу архивын лавлагаа цахимаар 141, мастер хувиас 39, цаасан суурьтай баримтаас 32 нийт 212, магадлагаа, тодорхойлолт 28 тус тус гаргаж өгч ажилласан байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 11 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 139 бичиж, 21 лавлагаа, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 234 бичиж, 3 лавлагаа өгч үйлчиллээ.

Иргэний бүртгэлийн талаар:

- ✓ Төрсний бүртгэл – 121 /эрэгтэй-70, эмэгтэй-51/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 23
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 8
- ✓ Эцэг тогтоолт – 41

- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 4
- ✓ Нас баралт –31
- ✓ Иргэний үнэмлэх олголт - 572
- ✓ Гадаад паспорт олголт – 259
- ✓ ОХУ-ын хавсралт - 3055
- ✓ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн –144
- ✓ Хот доторх шилжилт хөдөлгөөн – 190 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, “Монголын эмэгтэйчүүдийн сан” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид байлгах орчинг бий болгох нь” сургалтаар 4 сургагч багш бэлтгэгдэн ирсэн. Дээрх багш нар аймгийн хэмжээний цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 48 албан тушаалтанд “Бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг чадвар олгох нь” сургалтын модулийг заах орон нутгийн сургагч багш бэлтгэн бүлгийн болон туслах багш, эцэг эхчүүдэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж, бага насны хүүхдийг болзошгүй хүчирхийллээс хэрхэн хамгаалах талаар ойлголт мэдлэгийг өгч, 515 багш, 4210 гаруй эцэг эхчүүдийг хамруулсан. Мөн “Дэлхийн зөн” орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Сэлэнгэ, Бэлчир бүсийн цэцэрлэгийн багш, арга зүйч нарт “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтыг зохион байгуулж, 140 гаруй багш, арга зүйчийг хамруулсан.

Дэлхийн банк, Иргэний нийгмийн байгууллагуудын холбоо “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ерөнхий боловсролын 5 сургуульд хэрэгжүүлсэн “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн оролцоог хангах нь” төслийн хаалтын ажиллагааг бусад сургуулиудад танилцуулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ерөнхий боловсролын 35 сургуулийн 100 ажилтан, албан хаагчид оролцож, туршлага судалсан.

ЕБС-ийн 9 дүгээр ангийн сурагчдад математик, монгол хэл, монгол бичгийн хичээл зааж байгаа багш нарт зориулан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний бюлпринт, даалгавар боловсруулах, шинжлэх, даалгаврын хүнд, хөнгөний зэрэг, ялгах чадварыг тодорхойлох чадвартай болгох зорилгоор “Даалгавар боловсруулах арга зүй” сургалтыг зохион байгуулж, 90 багш, Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага, тэгш хамруулан сургах бодлого, насан туршийн боловсролын үйлчилгээний талаар Насан туршийн боловсролын үндэсний төвөөс сургалт зохион байгуулж хэлтэс, агентлагийн мэргэжилтнүүд, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч 25 хүн тус тус хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан “Эерэг хандлага, хөгжил-2020” уулзалт, лекцэнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1, 4 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн 6 бүлгийн 154 сурагч, “Аюулгүй сонголт” сэдэвт өсвөр үеийг өөрсдийгөө хамгаалах арга зүйд сургах сургалтад Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Сүхбаатар сумын 1, 2, 3, 4, 5, 6-р, Спортын болон Шаамар, Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулиудын 10, 11, 12-р ангийн 333 сурагч, эрүүл мэндийн багш нарыг хамруулж сурагчид амьдралынхаа зорилго, зорилтыг зөв тодорхойлох, сонголт зөв хийх чадвар эзэмшүүлэх сургалтад хамрууллаа.

Ерөө сумын иргэн, Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн ууган баатар Н.Бямбацогт агсаны нэрэмжит “АЛТАН НАМАР-2019” аймгийн аварга шалгаруулах дууны уралдааныг мэргэжлийн дуучид, ардын авъяастан гэсэн 2 ангиллаар зохион байгуулж, 29 ардын авъяастан, 6 мэргэжлийн дуучид оролцон, мэргэжлийн дуучдын ангилалд 1-р байранд ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулгын

дуучин Ч.Өрнөхбаяр, 2-р байранд мөн чуулгын дуучин Л.Уянга, 3-р байранд мөн чуулгын дуучин Ж.Оюундэлгэр, ардын авъяастан ангилалд 1-р байранд Жавхлант сумын ардын авъяастан Б.Оюунбат, 2-р байранд Хушаат сумын ардын авъяастан Б.Алтаншагай, 3-р байранд Жавхлант сумын ардын авъяастан Б.Баттулга нар тус тус шалгарсан.

Сүхбаатар сумын “ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН СҮХБААТАРЧУУД” ТББ-аас зохион байгуулсан сагсан бөмбөгийн нээлттэй тэмцээнийг хамтран зохион байгуулж, Сэлэнгэ, Дархан-Уул, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотын эрэгтэй 23, эмэгтэй 8 баг оролцож хурд хүчээ сорин өрсөлдсөн. Тэмцээний дүнгээр эрэгтэй төрөлд 1-р байранд Дархан-Уул аймаг “Дархан +30” баг, 2-р байранд Сэлэнгэ аймаг “Найзууд лиг” баг, 3-р байранд Сэлэнгэ аймаг “U17” баг, Эмэгтэй төрөлд 1-р байранд Баянхонгор аймаг “Мазаалай” баг, 2-р байранд Сэлэнгэ аймаг “Баруунхараа” баг, 3-р байранд Сэлэнгэ аймаг “Сэлэнгэ” баг тамирчид тус тус шалгарсан.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

МХЕГ-аас аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлгүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдох хяналт үнэлгээг хийсэн бөгөөд аймгийн Нэгдсэн эмнэлэг их эрсдэлтэй, сумын Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлгүүд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил, хариуцлага” зохион байгуулж, нэгдсэн эмнэлгүүдийн ёс зүйн хэсгийн хороо, өрх, сум, тосгон, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн ёс зүйн багийн ахлагч нарын нийт 200 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулж, ёс зүйтэй холбоотой сүүлийн үед гарсан хууль эрхзүйн баримт бичиг, ёс зүйн чиглэлтэй холбогдох мэдээллүүдийг өгч, ёс зүйн салбар болон хэсгийн хороодын үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгсөн.

Аймгийн Цагдаагийн газрын албан хаагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 100 албан хаагчдыг хамруулсанаас 81 хувь нь өвчлөлтэй гарсан бөгөөд шинээр 139 өвчлөлийг илрүүлсэн. Өвчтэй илэрсэн 25 хүнийг лавлагаа шатлалын эмнэлэгт, 5 хүнийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт тус тус шилжүүлсэн.

Эрүүл мэндийн яамнаас дэвшүүлсэн “ЭРҮҮЛ МЭНД 8/20” зорилт, “Тэмбүүг устгая” аян, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх цогц үзлэг оношилгооны 2 дах шатны үзлэгт Сант сумын 790 иргэнийг хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэн “Мэдээллийн цахим сан”-д баяжилт хийсэн.

“Ахмад настан-Хэрэглэгч” уриан дор нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд ахмад настануудад хүрч үйлчлэх зорилгыг тавьж, 16 ээлжийн сургалтад нийт 400 гаруй ахмадыг хамруулан “Сургагч багш”-аар бэлтгээд байна.

Шинээр төгссөн Баянгол сумын эрүүл мэндийн төвийн их эмч, Жавхлант сумын эрүүл мэндийн төвийн их эмч, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төвийн их эмч нарыг аймгийн Нэгдсэн эмнэлэгт 14 хоногийн чадавхижуулах зорилгоор вакумжуулсан сургалт хийж, эх барих эмэгтэйчүүдийн тасаг, хүүхдийн тасгуудад жижүүрлэн ажлын байрны дадлага, сургалтанд хамруулсан. Мөн төрийн сангийн санхүүжилтээр нүдний сувилахуй судлал, хүүхдийн сувилахуй судлал, бичил амь судлалын техникчийн төрөлжсөн мэргэшил олгох сургалтанд 5 тусгай мэргэжилтэнг лавлагаа шатлалын эмнэлгүүдэд төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэхээр сургаж байна.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 10-р сарын байдлаар аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй 642 байсан бол 405 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 127 ажлын байранд 109 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 285 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 653 болсон байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгонд мэргэшиж, дадлагажсан 39 мэргэжилтнүүдээр төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд халамжийн санд Улсын төсвөөс 15,162,612,5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 262175,0 мянган төгрөг, нийт 15,419,987,5 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

Орон нутгийн төсвийн орлогоос:

Тайлант хугацаанд 437 иргэнд 139570,0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд: Онцгой тохиолдлын тэтгэмжид 62 иргэнд 74400,0 мянган төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 375 иргэнд 65170,0 мянган төгрөгийг тус тус олгосон.

Улсын төсвийн орлогоос:

Тайлант хугацаанд 41104 иргэнд 12259929,7 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2594 иргэнд 3998147.6 мянган төгрөг
-Нийгмийн халамжийн тэтгэмжид 1795 иргэнд 1121715,3 мянган төгрөг
-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1664 иргэнд 747032,5 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмжид 2757 эхэд 351324,4 мянган төгрөг
-Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8909 эхэд 1162600,0 мянган төгрөг
-Цалинтай ээж хөтөлбөрт 6501 эхэд 2462257,3 мянган төгрөг
-Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 218 иргэнд 195181,5 мянган төгрөг
-Насны хишгийн тэтгэмжид 4775 ахмадад 719390,0 мянган төгрөг
-Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 5147 ахмадын 512521,6 мянган төгрөг

-Алдар цолтон ахмад настанд 71 ахмадын 69904,7 мянган төгрөг
-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 473 иргэний 207376,4 мянган төгрөг

-Хүнсний эрхийн бичгийн 6031 иргэнд 700273,6 мянган төгрөг
-Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулалд 169 иргэнд 12204,8 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Өрхийн амжиргааны түвшин тодорхойлох судалгаагаар Сүхбаатар, Хүдэр, Түшиг, Хушаат сумдын 24 өрхөөр зочилж өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгаа авсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсанд энэ сард 9 дуудлага ирж, хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал: Бие махбодын хүчирхийлэл 4, үл хайхрах хүчирхийлэл 4, зорилтот бус 1 байна.

Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 5 гомдол мэдээллийг хүлээн авч Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, мөн хуулийн 1.5 дахь хэсгийг үндэслэн хялбаршуулсан журмаар 1 хэрэгт тус тус ажиллагаа хийж прокурорт шилжүүлэн шийдвэрлэсэн.

Хүүхдийн эрхийн тухай Конвенц батлагдсаны 30 жилийн ойн хүрээнд Ерөнхий боловсролын 34 сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад хүүхдийн эрхийн тухай цахим хичээлийг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын 43 цэцэрлэгийн багш, 5000 гаруй хүүхдэд “Хүүхэд хамгааллын дүрэм” төслийн “Бүлтээхэй, Дэлдээхэй хоёр” хүүхэлдэйн 2 нэвтрүүлэг, хүүхэд хамгааллын аюулгүйн дүрэм, зөвлөмжийг үзүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 60 дугаар зарлиг, 2019 оныг “Хүүхэд хамгааллын жил”, Монгол Улсын Засгийн газраас зарласан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг Сант, Баруунбүрэн, Сайхан, Хүдэр, Ерөө, Орхон, Орхонтуул, Шаамар сумдад зохион

байгуулж, 186 өрхийн 820 гишүүн буюу 411 насанд хүрэгч, 412 хүүхэд хамрагдаж, өрх бүрт хүрч нөхцөл байдлын үнэлгээ хийн, хөгжлийн төлөвлөгөө боловсруулж сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө үзүүллээ. Мөн залуу гэр бүлийн харилцаа хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор "АХА" тэмцээн зохион байгуулж нийт 220 гэр бүл оролцож сум тус бүрээс нэгдүгээр байранд шалгарсан 13 хүнийг дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хурлыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулиудад 4 чиглэлийн хүрээнд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг өгч ажилласан.

Эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт, хууль сурталчлах ажлыг Цагааннуур, Жавхлант, Сант, Сайхан, Ерөө суманд зохион байгуулж, нийт 776 эцэг эхчүүдийг хамруулсан.

Сүхбаатар, Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 48 оюутан, Хүдэр, Ерөө, Сайхан, Шаамар сумдын ЕБС-ийн 327 сурагчдад "Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх нь", "Хорт зуршил" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.

Жил бүрийн 11-р сарын 11-ний өдрийг "ҮЛГЭРЧ ААВ, ЭЭЖ"-ийн өдөр болгон тэмдэглэж байгаа бөгөөд энэ жил Сайхан, Хүдэр, Ерөө, Шаамар сумын нийт 4 цэцэрлэгийн 55 хүүхдэд 9 төрлийн үлгэрийг ярьж, "Үлгэрч аав, ээж", "Халамжтай аав" зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 112 эцэг эхчүүдийг хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс батлагдсан хуваарийн дагуу 2 удаа явуулын хурлыг Сайхан, Мандал, Баянгол сумдад зохион байгуулж, 28 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй асуудлыг тодорхойлсон.

"Манлайлагч оюутан-3" уран илтгэлийн уралдааныг Дархан-Уул аймгийн Оюутны холбоотой хамтран Сэлэнгэ аймгийн харьяат оюутан залуусын дунд зохион байгууллаа. Уралдааны эхний шатанд 21 оюутан илтгэлээ илгээсэн бөгөөд 2 дугаар шатны шалгаруулалтанд шилдэг 10 оюутан илтгэлээ тавьж эхний 3 байрыг шалгаруулсан.

"ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ"-ын арга хэмжээг 11-р сарын 25-ны өдөр зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 100 сурагч иргэний андгай өргөж, 27 сурагч иргэний үнэмлэхээ гардан авлаа.

5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 32,2 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 11 дүгээр сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 34,2 тэр бум төгрөгийн орлого төвлөрүүлж 106,2 хувийн биелэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16842 тэтгэвэр авагчдад 58666587 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 6409 хүнд 2633536 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 286 хүнд 935645 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 476 хүнд 705315 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг 11-р сард 3 удаа хийж, 221 хүнээс, 11 хүнийг цуцалж, 21 хүн шинээр тогтоож, 189 хүн актаа сунгуулсан байна.

"Даатгалтай ирээдүй" сургалт өдөрлөгийг 15 сум, 2 тосгонд зохион байгуулж, 922 оюутан сурагч, 215 иргэн оролцож, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэнд, сайн дурын даатгалын талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээний чиглэлээр суманд хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор Орхон, Сайхан, Сант, Баруунбүрэн, Орхонтуул сумдад “Зөвлөн туслах” ажлын хэсгийг ажиллуулж, сумдын хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагаанд мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлээ.

Хүн амын дунд давсны зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, иоджуулсан давсны ач холбогдлыг сурталчлах, давс багатай хүнс болон хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна. Аянд Сант, Шаамар, Сүхбаатар, Жавхлант, Баянгол, Мандал, Орхон, Орхонтуул, Сайхан, Алтанбулаг, Цагааннуур, Ерөө, Хушаат, Түшиг сумдын 3 цэцэрлэг, 14 сургууль, 12 эмнэлэг, 3 хүнс үйлдвэрлэгч, 6 хоол үйлдвэрлэгч нийт 38 аж ахуйн нэгж оролцохоор бүртгүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн мэдээгээр 11 дүгээр сарын байдлаар 11 сумын 124 аж ахуйн нэгж, иргэдэд 866,4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, шинээр 182 ажлын байр бий болголоо. Зээлийн эргэн төлөлт 11-р сарын байдлаар давхардсан тоогоор 286 зээлдэгчийн 631,5 сая төгрөг төлөгдөж, нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 55,4 хувьтай байна.

Аймгийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн Дэд хорооны хуралаар 35 аж ахуйн нэгж иргэдийн төслийг хэлэлцэж, хамгийн өндөр оноо авсан 19 аж ахуйн нэгжийн 1,0 тэрбум төгрөгийн төслийг Хас, ХААН, Төрийн банкинд судлагдсанаас 15 аж ахуйн нэгж, иргэнд 846,6 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэр гарч, 14 аж ахуйн нэгж, иргэн 796,6 сая төгрөгийн санхүүжилтээ аваад байна.

“Хөдөө аж ахуйн хоршоод-2019” үзэсгэлэн худалдааг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, “АДРА” ТББ, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо хамтран “ЛАВАЙ” худалдааны төвд 11-р сарын 14-нөөс 21-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд үзэсгэлэнд тус аймгийн 11 хоршоо мах махан бүтээгдэхүүн, сүү цагаан идээ, хүнсний ногоо, зөгийн бал, даршилсан ногоо, гар урлал, хувцас эдлэл зэрэг 11 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 11 сая төгрөгийн борлуулалт хийжээ.

Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээгээр энэ онд бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг Мандал, Баянгол, Жавхлант, Хушаат, Түшиг, Сант, Орхон, Орхонтуул, Сайхан, Баруунбүрэн сумдад нийт 75000 га бэлчээрийн талбайд хийж гүйцэтгэлээ.

Малчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхэд орон нутгийн малчдыг идэвхижүүлэх зорилгоор Мандал сумын Засаг даргын Тамгын газар, “Бороо Гоулд” ХХК-тай хамтран Мандал сумын эрчимжсэн мал аж ахуй эрхлэх сонирхолтой, фермерийн аж ахуй эрхэлж буй 35 малчныг Зүүнбүрэн суманд мах, сүүний чиглэлийн үхэр үржүүлэгч “Газар агро” ХХК, “Алтан тариа” ХХК-ий үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгууллаа.

“Зарим архаг халдварт өвчингүй тайван байдлыг баталгаажуулах шинжилгээ-2019” тандалт, сорил шинжилгээний ажлыг удирдамжийн дагуу Мал эмнэлгийн Ерөнхий газар, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, аймгийн Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран зохион байгуулж байна.

“Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль, холбогдон гарсан зарим журам, зааварын талаар 985 малчин, мал бүхий иргэдэд мэдээ мэдээлэл хүргэж ухуулан таниулсан. Зах зээлд худалдан борлуулагдаж байгаа 35999 толгой мал амьтан, 879713 тн мах, махан бүтээгдэхүүн, 41476 л сүү сүүн бүтээгдэхүүнд, 4042 ш арьс шир түүхий эдэд мал эмнэлгийн гэрчилгээ олгож баталгаажуулав.

Энэ сард аймгийн хэмжээнд Баруунбүрэн Сант, Мандал, Түшиг Орхон суманд адуу 393, үхэр 1106, тэмээ 4, хонь 5866, ямаа 3587, гахай 5 нийт 10961

толгой мал амьтан шилжин ирсэн, 16 аймагт адуу 1363, үхэр 2418, тэмээ 89, хонь 8542, ямаа 5355, гахай 6, зөгий 40 нийт 17813 толгой мал, амьтан мал эмнэлгийн хяналтан дор отор нүүдлээр шилжин явсан мэдээтэй байна. Мал эмнэлгийн нэгжүүд орон нутгийн мал сүрэгт мал амьтны эрүүл мэндийн үзлэг хийж адуу 101003 толгой, үхэр 211373 толгой, тэмээ 480, хонь 741769 толгой, ямаа 540207 толгой, нийт 1.594.832 толгой мал хамрагдлаа.

Бруцеллёз, боом, гахайн мялзан өвчний вакцинжуулалтын дараах дархлааны түвшин тогтоох, өрхийн малын эрүүл мэндийн дэвтэр ашиглалтыг үнэлж, өмнө нь вакцинжуулалтанд хамрагдаж байсан түүхийн талаар мэдээлэл цуглуулах, судалгааг явуулсан. Судалгаанд хамрагдсан өрх малчдад зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Газрын төлбөр, татварын программыг 2019 онд улсын хэмжээнд шинэчлэн нэвтрүүлэхтэй холбоотойгоор сүүлийн 5 жилийн хугацааны газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн мэдээллийг нягтлах, газрын кадастрын мэдээллийн сантай тулгах, шалгах нөхөн оруулах засварлах ажлыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулж, арга зүйн зөвлөмж чиглэлээр ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд газрын кадастрын мэдээллийн “web систем”-д 7256 нэгж талбарыг шинэчилсэн бүртгэлд, газар эзэмших эрхийн гэрээний хугацаа дуусгавар болсон 5252 нэгж талбар, эрхийн гэрээ нь цуцлагдсан 1752 нэгж талбарын гэрээг шинэчилсэн бүртгэлд шилжүүлж, газрын төлбөртэй холбох ажлыг хийлээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/376 тоот захирамжийн дагуу Ерөө, Хүдэр сумдын ойн ангитай хамтран ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ойжуулалтийн ажлын талбайг хэмжих ажлыг зохион байгууллаа. Ерөө суманд 2018-2019 оны байдлаар өөрийн хөрөнгөөр 26 аж ахуйн нэгж 270 га газарт ойжуулалт хийдсэн, Хүдэр суманд Ойн мэргэжлийн байгууллагууд болох “Ургамал дөрөө” ХХК, “Хүдэр амжаа” ХХК-ны бага тарвагтайд хамтаран 18 га, “Сэлэм хайрхан” ХХК, “Хүдэр дэлгэрэх” ХХК-ны сөдтэйд хамтарсан 6 га, “Хүдэр нумт” ХХК-ны сөдтэйд 1 га, Мөнххантайшир ХХК-ны бага тарвагтай 1 га, “Хүдэртэйн буян” ХХК-ны тарвагтайд 1 га газарт тус тус ойжуулалт хийсэн байна.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд аймгийн төвийн дэд бүтцийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн барилга байгууламжийг мэдээллийн санд бүртгэж орууллаа. Үүнд сургуулийн барилга 7, цэцэрлэгийн барилга 8, эмнэлэгийн барилга 7, Сүхбаатар сумын нийтийн орон сууцны 1-13, 15-20 дугаар байрнуудыг мэдээллийн санд орууллаа.

Барилгын техник, хяналтын чиглэлээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжиж буй Хушаат сумын сургуулийн барилгын их засварын ажил, Баянгол сумын 1,6 км бетон авто зам тавих ажил, “Дэлгэрхаан” аялал жуулчлал, амралт, сувилалын газрын гадна цахилгаан хангамжийн ажил, Сүхбаатар сумын төвөөс Сайханы хөтөл хүртэлх хатуу хучилттай авто замын ажил, Орхонтуул сумын 2-р сургуулийн их засварын ажил, Жавхланта суманд амралт биеийн тамирын талбай барих ажил, Ерөө сумын Бугант тосгонд хийгдэж буй цэвэрлэх байгууламжийн барилгын гадна цахилгаан хангамжийн ажил, Алтанбулаг сумын орон сууцны байруудын цэвэр, бохир усны шугамын засварын ажлуудад тус тус улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 22 ажил эрх шилжиж ирсэн бөгөөд зураг төсөв ирсэн 22 ажил, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 8 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 8 ажлын зураг төсөв ирснийг гэрээ байгуулах эрх олгож ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 36 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 29

ажлын зураг төсөв ирсэн. 7 ажлын зураг төсөв ирээгүй байна. Үүнээс 1 ажил үнэлгээний шатандаа 28 ажил нь гэрээ байгуулах эрх олгосон байна.

Тендерүүдийг 100 хувь цахимаар зохион байгуулаж байна.

Сум, агентлагийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д оруулахад хяналт тавьж ажилласан.

Төрийн өмчийг ашиглах өмч эзэмшлийн гэрээг дүгнэх ажлыг аймгийн төрийн өмчит 34 хуулийн этгээдийг хамруулсан.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Мандал, Сайхан, Баруунбүрэн, Цагааннуур, Хушаат, Түшиг сумдын 47 ойн мэргэжлийн байгууллагад ойн мэргэжлийн байгууллагын түвшин тогтоох үзлэгийг хийж гүйцэтгэлээ. Ойн мэргэжлийн байгууллагын түвшинд хангалттай үйл ажиллагаа явуулж чадах 15 ойн мэргэжлийн байгууллага байгаагаас нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэрлэл явуулж байгаа 9 ойн мэргэжлийн байгууллага, үйл ажиллагаагаа цаашид явуулж болохуйц 15 ойн мэргэжлийн байгууллага, үйл ажиллагаа нь хангалтгүй байгаа 17 ойн мэргэжлийн байгууллага байна.

Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангитай 2,0 сая төгрөг, Бэлчирийн бүсийн сум дундын ойн ангитай 1,0 сая төгрөг, Хүдэр сумын Ойн ангитай 1,0 сая төгрөг, Хараа бүсийн сум дундын ойн ангитай 1,0 сая төгрөг, Ерөө сумын “Хөвчийн ой” ойн нөхөрлөлтэй 2,0 сая төгрөг, Алтанбулаг сумын “Баян чацаргана” нөхөрлөлтэй 1,0 сая төгрөг, Баруунбүрэн сумын “Түвшинбүрэн” ойн нөхөрлөлтэй 1,0 төгрөг, Сант сумын “Баян баавгайт” нөхөрлөлтэй 1,0 сая төгрөг, нийт 1,0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан санхүүжилтийн 80 хувийг олгоод байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалтын ажлыг “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ хийж гүйцэтгэсэн.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ойжуулалт, ойн зурвас байгуулах, хуш жодооны тарьц, суулгацаар ойжуулалт хийх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ажлын хэсэг Хүдэр, Ерөө, Мандал, Цагааннуур, Баянгол, Баруунбүрэн, Орхон, Жавхлант сумдад ажиллаж, ойжуулалтын ажлыг актаар үйлдэн хүлээн авсан.

“Экологид ээлтэй бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаа-2019” арга хэмжээнд Ойн санг гэрээгээр эзэмшигч 31 нөхөрлөлийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцлоо.

Сэлэнгэ аймгийн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарах зарим асуудал” сэдэвт сургалтыг 11-р сарын 22-нд аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулж, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын ажилтан албан хаагч нарт мэргэжлийн ур чадвар, харилцааны соёл ёс зүйг дээшлүүлэх сургалт, хэлэлцүүлэгийг хийлээ.

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/390 тоот захирамж, сумын Засаг даргын 2019 оны А/138 тоот захирамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нартай хамтран Алтанбулаг сум "Гамшгаас хамгаалах бэлэн байдал"-ын үзлэгийг зохион байгууллаа.

Алтанбулаг суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цэвэрлэх байгууламж”-ийн ажлыг 11 дүгээр сарын 11-нд эхлүүлсэн. Улсын Их Хурлын

гишүүн Н.Оюундарь сумын ЭМТ-д түргэн тусламжийн автомашиныг хүлээлгэн өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Бүргэдэй 1-р багт байрлах 3-р цэцэрлэгийн нээлтийн үйл ажиллагааг 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Уг цэцэрлэг нь 50 хүүхдийн ортой, 2 бүлгээр хичээллэх бөгөөд 40 хүүхдүүд бүртгүүлж, 12 багш ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Алтанбулаг чөлөөт бүс болон ОХУ-ын бүгд найрамдах Крым Улсын эдийн засгийн чөлөөт бүсийн хооронд олон талт хамтын ажиллагааны талаарх санал арга хэмжээ боллоо. “Олон Улсын Дистрибьютер-2019” арга хэмжээнд оролцсон ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Бүгд Найрамдах Крым улсын байнгын төлөөлөгчийн нэгдүгээр орлогч С.Н.Кудрин, Монгол дахь ОХУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газрын тэргүүн М.В.Васильев болон Эрхүү мужийн “Бизнесконтакт” компаний захирал А.А.Сидоров нарыг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагч Ж.Амаржаргал хүлээн авч уулзлаа.

Сумын ЕБС, соёлын төвийн номын сан хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Номын баяр-2019” арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний үеэр Шилдэг гэр номын сантай өрх, Шилдэг уншигч анги хамт олон, Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгтэн шалгаруулж, ЕБС-ийн сурагчдын дунд “АХА”, “Алтан хонх” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж нийт тэмцээнд 90 сурагч хамрагдлаа.

ЕБС-ийн сурагчдын урлагийн үзлэг арга хэмжээг 2 насны ангиллаар явуулж, дөрвөн төрлөөр нийт 800 орчим сурагч хамрагдлаа.

Тайлант сард “Өөрийгөө таньж хөгжүүлэе. Бусдыг хүндэлж баярлуулъя” 7 хоногийн аян зохион байгуулсан. Аяны хүрээнд мэндчилгээний өдөр, талархал илэрхийлэх өдөр, бахархалын өдөр хүндэтгэлийн өдөр арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд зохион байгуулж буй “Шүд гараа угааж хэвших нь эрүүл байхын үндэс аян-6” аяныг хэрэгжүүлж, хүүхдийн гараа угааж буй байдлын судалгааг өдөр бүр авч, хяналт тавин ажиллаж байна.

Зүүнбүрэн сум:

Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан ЕБС-ийн Хүүхдийн оролцооны байгууллагын удирдлагын зөвлөлийн төлөөллийг сумын Засаг дарга хүлээн авч уулзан хүүхдийн 8-р чуулганаас гарсан шийдвэртэй танилцаж, хамтран ажиллахаар болсон. Ерөнхий боловсролын сургуулийн 18 бүлгийн ангийн дарга нарын уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж Манлайлалын тухай ойлголт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн тухай ойлголт, Иргэний бүртгэлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг тус тус зохион байгууллаа.

“МЕРСИ-КОР” ОУБ-аас зохион байгуулсан “Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах” 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 20 гаруй иргэдийг хамрууллаа.

Хүүхдийн сонирхлын дагуу эцэг эхчүүдтэй хамтран дугуйлан хичээллүүлж, 258 сурагчийг хамруулж байна. Мөн сургуулийн 528 сурагч, багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, зөвлөгөө өглөө.

ОХУ-ын Буриад улсын Хиагтын районд зохион байгуулагдсан өсвөрийн Самбо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд тус сургуулийн сурагч Ц.Эрдэнэтогтох, Н.Ихтамир нар оролцож, алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Мөн Орхон аймагт зохиогдсон МУ-ын гавъяат тамирчин Нармандахын нэрэмжит Жүдо бөхийн олон хотын тэмцээнээс сурагч Н.Ихтамир хүрэл медаль хүрсэн.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төв 28 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулатороор 202 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 118, урьдчилан сэргийлэх үзлэгээр 38, диспансерийн хяналтаар 23, гэрийн идэвхтэй эргэлтээр 11, дуудлагаар 12 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар эхийн эндэгдэлгүй ажиллаж байна. Аймгийн нарийн мэргэжлийн

эмчийн хяналтанд 5 эх амаржиж, цусны гемоглобин, тэмбүү илрүүлэх, ХДХВ шинжилгээнд 12, артерийн даралтын үзлэгт 58 иргэнийг тус тус хамрууллаа.

2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 23 иргэнд 49 га газрыг эзэмшүүлэх ажлыг зохион байгууллаа.

Үр тарианы зориулалттай 1 аж ахуй нэгж байгууллагын 28 га, хүнсний ногооны зориулалттай 2 иргэний 3,5 га, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 4 иргэний 4 иргэний 3,12 га газрын эзэмших эрхийг шилжүүллээ. Аймагт кадастрын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Налжирлха” ХХК, “Сэлэнгэ тулга” ХХК, “Сэлэнгэ кадастр” ХХК-иудтай хамтран 18 нэгж талбарт кадастрын зураг хийлгэж эргэлтийн цэгийг баталгаажууллаа.

Газрын төлбөрийн “Ланд менежер” программд төлбөрийг үнэн зөв оруулж, эзэмших эрхийн 380 нэгж талбар, өмчлөлийн 350 нэгж талбарын төлбөрийг шинэчилсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Малын эмч нарын анхдугаар их хуралд Мал эмнэлгийн тасгийн дарга, “Энхбүрэн сүрэг” МЭҮН-ийн захирал нар, мөн зохион байгуулагдсан махны нөөц бүрдүүлэх, махны өргөтгөсөн худалдаанд 3 малчин өрх 45 хонь, ямааны махыг борлуулж оролцсон.

Баруунбүрэн сум:

Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн баярын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний дагуу “Атарчдын уянга дуу”-ны уралдаан, “Атар-60” жилийн ойн дурсгалын хөшөө, самбарын загварын уралдааны удирдамжийг боловсруулан сумын Засаг даргаар батлуулан зарын самбаруудаар болон мэдээллийн сүлжээнүүдээр тавьж сурталчлан ажиллаж байна. Мөн “Атар 60” Улсын ойн арга хэмжээнд 10 төлөөлөгч оролцууллаа.

Сумын төвийн хүнсний дэлгүүрүүд болон сургууль, цэцэрлэг, үрийн будааны агуулахуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг “Мөнх Ариун” ХХК-аар хийлгэлээ.

Хүнсний улаан буудайн урамшууллын материалыг бүрдүүлж ХХААГ-т хүргүүлсэн.

Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалт хийж үржилд орууллаа. 2019 оны 11 дүгээр сарын 13-18-ны хооронд нийт 50 иргэн 10 портерийн хамт бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг 10000 га газарт хийж тэмцлийг ажлыг явуулсан.

Улсын Онцгой комиссын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн өргөтгөсөн хуралдааны шийдвэрийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 30-аас, 11 дүгээр сарын 03-ныг дуустал Нийслэлийн мал эмнэлгийн газартай хамтран махны өргөтгөсөн худалдаанд 5 малчин адуу-2, үхэр-12, хонь-135, нийт-149 ширхэг гулууз мах, болон дайвар бүтээгдэхүүн худалдан борлуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Төрийн ордонд “Малын эмч нарын их хурал”-ыг зохион байгуулсан үйл ажиллагаанд мал эмнэлгийн нэгжийн эмч, захирал нарын хамт оролцсон.

Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн газрын Улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарган бруцеллёз өвчний лабораторийн шинжилгээгээр эерэг гарсан хээлтүүлэгчийг зааврын дагуу үржилд ашиглахгүй /хөнгөлсөн/ болгож, тухайн хуц, ухна маллаж байсан суурьт ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Африкийн гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гахайн аж ахуй эрхэлж байгаа 8 өрхөд уг өвчний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага материал, зөвлөмжийг тараан гахайн хашаа байранд ариутгал халдваргүйжүүлэлтийг заавар журмын дагуу хийж гүйцэтгэлээ.

“Номголжин” ХКК нь өөрийн хөрөнгийн ойжуулалтаар 5 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Бага, дунд ангийн сургалтын менежерүүд хичээлд суух цагийн хуваарь гарган багш нарын хичээлд сууж анализ дүгнэлт гарган хичээлийн талаар багш нэг бүртэй ярилцаж тухайн хичээлтэй холбоотой засан сайжруулах цаашид анхаарах

асуудлын талаар багш нарт зөвлөгөө өгч ажиллаа. Мөн багш нар бие биенийхээ хичээлд сууж арга барилаас нь суралцан сургалтандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Сургуулийн “Урлагийн наадам-2019” тэмцээнийг 1-12-р ангийн хамруулан зохион явуулахад 450 гаруй багш, сурагч хамрагдсан.

Цэцэрлэгт хамран сургах тойргийн /сарын турш/ 3680 хүүхэд хамрагдахаас 2834 хүүхдийг 77 хувьтай байна. Багш, туслах багш нар “Навч, Амьтан” сэдвийн хүрээнд зориуд зохион байгуулах үйл ажиллагаандаа нийт 120 төлөвлөлт батлуулан 72 ширхэг том үзүүлэн, Тоо тоолол, Хэл яриа болон бусад сургалтанд хэрэглэх зорилгоор 215 ширхэг тарааж өгөх материал хийж ашиглаж байна

2019 оны 10-р сарын 24-нд аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн “ӨӨДЛӨН ДЭВЖИХ” чуулга уулзалт сумын эмэгтэйчүүд уулзаж, урлагийн тоглолт, үзэсгэлэн гаргаж, хурал зохион байгууллаа

Шаамар сум:

Улс тунхагласны 85 жилийн ойг угтан төрийн жинхэнэ албан хаагчдын сонгон шалгаруулалтанд тэнцэж төрийн ажил үйлчилгээг эрхэлж буй сумын Татварын байцаагч, сум, тсогоны Нийгмийн даатгалын байцаагч нарын төрийн албан хаагчийн тангарагийг өргүүлж, төрийн алтан соёмбот далбаанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Мөн сум, тосгоны төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын дунд төрийн албаны шинэчилсэн хууль, дүрэм, журмаар АХА тэмцээн, холимог гар бөмбөгийн тэмцээн, урлагын арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээнд шаардлагатай 380000 төгрөгийг Тамгын газрын хичээл үйлдвэрлэлийн зардлаас гарган зарцууллаа.

Махны нөөц бүрдүүлэх тухай “Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын албан бичиг, мах бэлтгэлийн талаар өгөх зөвлөмж”, “Сэлэнгэ аймгийн Засаг даргын махны өргөтгөсөн худалдаанд оролцох тухай” албан бичгийн дагуу малчин, мал бүхий 25 иргэнтэй уулзаж, махны нөөц бүрдүүлэх, махны нөөцөнд нийлүүлэх малын судалгааг авч аймгийн мал эмнэлгийн газарт судалгааг гаргаж өгсөн.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяны хүрээнд сумынхаа “Бүжинхэнэ” 1-р цэцэрлэг, “Баясгалант ирээдүй” 2-р цэцэрлэг, ЕБС, “Эрүүл мэндийн төв”-д хүлээлгэн өгч, 2 удаа хяналт шалгалтыг хийгээд байна.

“Атар 60-Алтан намар” хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын баярын арга хэмжээг зохион байгуулсан.

Сумын иргэдийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 2350 м2 галын түлээ бэлтгүүлэхээр Хүдэр сумын байгаль орчны байцаагчтай хамтран ажиллаж, 50 гаруй иргэн 200 гаруй м3 галын түлээ бэлтгэсэн мэдээтэй байна

Татварын ерөнхий хууль, Нэмүү өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлыг тогтмол хэрэгжүүлэх талаар шинээр худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа 2 хүнсний дэлгүүрт татварын шинэчлэгдсэн хуулийг сурталчилж Е-баримт хэвлэдэг болсон.

Мандал сум:

Төрийн албаны зөвлөлөөс зарласан “Төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх жил”-ийн хүрээнд сумын Төрийн албан хаагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор хийгдсэн төрийн байгууллагын үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаанаас гарсан үр дүнд дүгнэлт хийж, “Эртэч Монгол” хөтөлбөрийн JCI leader ОУ-ын байгууллага “Эерэг сэтгэлгээний давлагаа” төслийн удирдагчийг урин “Бухамдсан хэцүү хэрэглэгчидтэй харилцах аргууд” “Ямагт хэрэглэгчийн зөв байдаг”, “Хэрэглэгчдийн зан төлөв, онцлог”, “Алдаа гарсан л бол нэн даруй залруулга хийх”, “Алдааг залруулах арга” сэдвээр төрийн захиргааны 51 албан хаагчид, “Хандлага бол бүх зүйлийн үндэс суурь”, “Инээмсэглэл бол амжилт”, “Эерэг хандлага амжилтын үндэс”, “Эерэг сэтгэлгээг төлөвшүүлэх 20 арга” сэдвээр сумын төсвийн байгууллагын 500 албан хаагчдад төрийн албан хаагчдын хөгжлийн сургалтыг зохион байгууллаа.

“Баян хангайн” 6-р багт “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгуулж, газар, халамж, ойн анги, нийгмийн даатгалын мэргэжилтнүүд оролцож, 78 иргэнд үйлчилгээ үзүүлээ.

Сумын Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулж, сумын хэмжээнд 16 нас хүрч буй 384 хүүхэд байгаагаас 74 хүүхэд анх удаа иргэний цахим үнэмлэхээ гардан авлаа.

“Монголын оюун ухааны академи”-ийн Зүүнхараа дахь салбарын 5 жилийн ой тохиолоо. Тус салбар нь ЕБС, СӨБ-ын байгууллагуудад нэрэмжит анги байгуулан үйл ажиллагааны гэрээний хүрээнд хамтран ажиллаж байна. Хүүхдийн хөгжлийн дэмжигч шилдэг байгууллагаар Мандал сумын Улсын тэргүүний 3-р цэцэрлэг шалгарлаа. 2014 онд 2 сургагч багш 45 сурагчтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өнөөг хүртэл нийт 1500 гаруй сурагчдыг оюуны хөгжлийн олон талт сургалтанд хамруулж оюуны спортын тамирчдыг бэлтгээд байна.

Сумын ахмадын хороо, “Хараа” нийтийн цэнгээнт бүжгийн клубтэй “Шилдэг хос” шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээний 50-аас дээш насны ангилалд нийт 20 гаруй хос оролцож шилдгүүдийг өргөмжлөл, медаль, цомоор урамшуулсан. Шинээр төрсөн 46 хүүхдийг бүртгэж, өрхийн мэдээллийн санд бүртгэв. Тайлант сард өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдахаар шинээр хүсэлт ирүүлсэн 343 өргөдлөөс 279 хүсэлтийг шийдвэрлэж 81.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор жижиг зээлд хамрагдах иргэний бүртгэлийг хүлээн авч, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. 11-р сард өссөн дүнгээр 35 иргэн бүртгэлд хамрагдсан. Нийтийг хамарсан ажил арга хэмжээний хүрээнд Хээрийн оготно устгах ажлыг 11 дүгээр сарын 19-нөөс 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгүүллээ.

Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэйгээр газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жилийн ойг тохиолдуулан тариаланч, ногоочдын 40 гаруй төлөөллийг Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.

“Давс багатай бүтээгдэхүүн аян”-д оролцсон аж ахуй нэгж байгууллагын бүтээгдэхүүний дээжийг 3 шатлалтайгаар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулан хариуг, тайлангийн хамт аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ. Мөн мялзан өвчний тандалт судалгааг 4 өрхийн 20 гахайнаас цусны дээж авч, аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүллээ.

Залуу малчдын туршлага судлах аялалыг зохион байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч 45 иргэнийг оролцуулан Зүүнбүрэн сумын “Газар агро” ХХК, “Алтан тариа” ХХК-ий фермийн туршлага судалж, Монгол Улсын мал аж ахуйн доктор Б.Лувсаншарав багшийг урьж сургалт зохион байгууллаа.

Тайлант сард талбай тусгаарлалт хийлгэх хүсэлт гаргасан 2 нөхөрлөл, 8 аж ахуйн нэгж, байгууллагын 1 нөхөрлөл, 5 аж ахуйн нэгж байгууллагад 67 га талбай тусгаарлалт хийж, материалыг боловсрууллаа. 10 нөхөрлөл, 11 аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглээний 820 м³, түлээний 1193 м³ буюу нийт 2013 м³ мод бэлтгэх зөвшөөрлийг олгож, 4 иргэн, 4 нөхөрлөл, 16 аж ахуйн нэгж, байгууллагын 1237,4 м³ хэрэглээний, 385,7 м³ түлээний нийт 1623,1 м³ мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 28 иргэнд 5,31 га газрыг өмчлүүлж, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэхээр 26 иргэн, аж ахуй нэгжийн 8,14 га газрыг сумын Засаг даргын шийдвэр гаргасан шийдвэрлэсэн. Мөн газрын барьцаанд 11 иргэн, 1 аан-н газар эзэмших гэрчилгээг барьцаанд бүртгэж, газар эзэмшигч 52 иргэн аж ахуй нэгж байгууллагад гэрээ, гэрчилгээ олгож үйлчилсэн.

Баянсуудалын 3-р багийн Булаг, Сэвсүүл, Минжийнхангай 7-р багийн Сансарын гудамжуудад нийт 60 ширхэг 100 ватт-ын чадалтай гэрэлтүүлэг

суурилуулж ашиглалтад оруулсан. Түнхэл тосгонд Түнхэл голын эрэг дагуу газар өмчилж авсан гэр хорооллын 40 айл өрх жил бүрийн 2-4 дүгээр сард Түнхэл гол гэсэх үеэр болон 7, 8 дугаар саруудад усархаг борооны үерт өртдөг эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зорилгоор “Дэлхийн зөн Зүүнхараа” ОНХХ, “Бороо Гоулд” ХХК нартай хамтран 1,4 км үерийн далан байгууллаа.

Баянгол сүм

Аймгийн Засаг даргын 2019 оны А/390 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын 2019 оны А/228 тоот захирамжаар гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгууллаа. Команд штабын сургуулиар сумын Засаг даргаас “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” захирамжийг гарган 2019 оны 11 дүгээр сарын 6-ны 09 цаг 00 минутаас 11 дүгээр сарын 7-ны 20 цаг 00 минут хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллалаа. Команд штабын сургуулийн бэлтгэл бэлэн байдлыг шалгах, зөвлөн туслах зорилгоор аймгийн Онцгой байдлын газрын орлогч, төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, гал түймрийн улсын хяналтын байцаагч нар ажилласан бөгөөд команд штабын сургуулийг удирдан зохион явуулж, “Дүүрэн хангалттай” үнэлгээ өгсөн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Г.Бямбаа болон ИТХ-ын тэргүүлэгчид 11 дүгээр сарын 14-нд тус суманд ажиллаж сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XV хуралдаан 11 дүгээр сарын 15-ны өдөр хуралдаж, сумын Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2018 оны биелэлт, 2019 оны хэрэгжилтийн явц, 2020 оны төслийг хэлэлцсэн.

Сумын Засаг даргын санаачлагаар ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдад Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Шарын гол нүүрсний уурхайтай гэрээ хийж% хөнгөлөлттэй нөхцлөөр нүүрс олголоо.

Дэлхийн Зөн Олон Улсын Зүүнхараа хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Бэлэн бай” сургалтыг 80 малчин, мал бүхий иргэдийг хамруулан зохион байгууллаа.

Сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг байгуулж, мэрэгчидтэй тэмцэх ажлын төлөвлөгөө гарган 8000 га талбайд огтоно устгалын ажлыг зохион байгууллаа. Уг ажилд сумын зорилтот бүлгийн 15 иргэн, 6 техник эзэмшигч, 24 малчин оролцуулан ажлын хэсгийн гишүүд ахлан 6 хээрийн ажлын бүлэгтэй гэрээ хийн огтоно устгалын ажлыг хийж дуусгасан.

Олон Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн сэтгэлзүйн хэрэгцээт үйлчилгээ авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хамтдаа хөгжье” өдөрлөгийг 11-р сарын 20-ны өдөр зохион байгуулж, 80 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан. Өдөрлөгийн үеэр “Хүүхдийн насны онцлог эерэг хүмүүжлийн арга”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн өөрчлөлт, Эрүүл мэндийн төвөөс сэргээн засах эмчилгээний талаар мэдээлэл, сургалтууд болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга хэмжээний талаар ярилцлага, хэлэлцүүлэг, гар бөмбөг, дартс, караоке дууны тэмцээн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан, сайн үйлсийн аянг өрнүүллээ.

Аймгийн БСУГ-ын хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг 11 сарын 12-аас 15-ны өдрүүдэд зохион байгууллаа. 3-12-р ангийн 25 бүлгийн 729 суралцагчид 13 төрлийн хичээлээр шалгагдлаа. Шалгалтанд мэргэжлийн багш нарыг хуваарилан шалгалт авсан өдөр бүр дүн оноог үнэлгээний шалгуурын дагуу засуулж, дүнгийн нэгтгэлийг хийж, дүгнэж ажиллалаа. 11 дүгээр сарын 22-нд сумын сургуулийн 12-р ангийн суралцагчид анги удирдсан багш нарын хамт Төрийн ордонтой танилцлаа.

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн зөвлөлөөс зарласан “Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангацгаая” бүтээлч ажлын уралдаанд амжилттай оролцож тэргүүн байр эзэллээ.

МОУА-ийн Зүүнхараа гэрээт салбарын 5 жилийн ойн арга хэмжээнд оролцлоо. Энэ ойн арга хэмжээний үеэр манай сургууль “Хүүхдийн хөгжлийг дэмжигч - Шилдэг байгууллага”-аар шалгарлаа. Арга хэмжээнд МОУА-ийн захирал Х.Хатанбаатар оролцож “Тархиа үр дүнтэй ашиглая” лекцийг уншлаа.

НҮБ-ын Хүүхдийн сан боловсруулсан “Хялбаршуулсан хичээл”-ийг хүүхэд багачуудад Конвенцийн талаар мэдээлэл хүргэх зорилгоор 6-12-р ангийн АУБ нар нийт 440 суралцагчдад зохион байгуулав. Мөн хүүхдийн хүмүүжлийн эерэг арга сургалтын агуулгын хүрээнд Л.Атарцэцэг багштай 9б, Б.Цэцэгмаа багштай 10а ангийн суралцагчдад “Өсвөр насны хүүхдийн онцлог, анхаарах зүйл, зан чанар” сэдвээр сургалтыг явууллаа. Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнийг урьж, 12-р ангийн 43 суралцагчдад “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ” сургалтыг явууллаа.

Мандал сумын IV сургуулиас “Алтан намар” газар зүйн бага сорилго арга хэмжээг 11-р сарын 8-нд 7-12 дугаар анги, багш гэсэн ангилалаар Хараа бүсийн 6 сургуулийн дунд зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд сумын сургуулийн багш сурагчид оролцож, 7А ангийн суралцагч Ц.Нарангэрэл 4-р байр, 8а ангийн суралцагч Б.Төгөлдөр 2-р байр, 9б ангийн суралцагч Т.Мичидмаа 1-р байр, 10б ангийн суралцагч М.Номингэрэл 4-р байр, 11а ангийн суралцагч Ө.Сайнпүрэв 1-р байр, 12а ангийн суралцагч Н.Маралмаа 3-р байр, багш У.Лхагважаргал 1-р байрыг тус тус эзэлж, нийт 186.5 оноогоор тэргүүн байр шилжин явах цомын эзэд боллоо.

Аймгийн төв Сүхбаатар суманд 11-р сарын 15-17-ны хооронд болсон “Хөгжилд тэмүүлсэн Сүхбаатарчууд” сагсан бөмбөгийн нээлттэй тэмцээн амжилттай зохион байгуулагдаж багш Э.Энхбаяр эрэгтэй U17 баг, эмэгтэй Баруунхараа багийг дасгалжуулж оролцлоо. Тус тэмцээнэд Баруунхараа эрэгтэй баг шигшээ 8-р байр, U17 баг 3-р байр, Баруунхараа эмэгтэй баг 2-р байранд шалгарлаа. Энэ тэмцээнд манай сургуулийн 12б ангийн сурагч Т.Тэмүүжин хүрэл медаль, Б.Мөрөн мөнгөн медаль хүртсэн. Мөн 11-р сарын 9-10-нд “Уран бийр” гар зургийн дугуйлангийн суралцагчид HUGOandCOLOR хүүхдийн зургийн клубээс зохиодог Дүрслэх урлагийн улсын олимпиадад багаараа амжилттай оролцож, 2б Н.Соёлмаа 3-р байр, Л.Маргад тусгай байранд шалгарч шүүгчдийн нэрэмжит шагнал хүртлээ.

Мандал суманд 11-р сарын 14-нд зохион байгуулагдсан “Ногоон гэрэл цагаан шугам” уралдаанд оролцох сурагчдын үзүүлбэрт зориулсан авто машины 9 загвар хийсэн ба тус уралдаанд манай суралцагчдын баг 2-р байранд шалгарлаа.

Улаанбаатар хотын 380 жилийн ойн хүрээнд ЕБС-ийн дунд ангийн суралцагчдын дунд зарласан “Бидний бүтээл сансарт” уралдаанд манай дугуйлангийн суралцагч С.Шинэжил, Г.Сувд-Эрдэнэ нарын бүтээл амжилттай оролцож, талархал, “АСТРОПАРК” үзэх эрхийн бичгээр шагнагдлаа.

Үндэсний бөхийн “Аймгийн дэд засуул” Дамбын Лхачинсүрэн агсны нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах “Ирээдүйн аварга” үндэсний бөхийн барилдаан, “Цолчин засуул” цол дуудах тэмцээн 2019 оны 11 сарын 16-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. “Цол дуудах” тэмцээнд 6-12-р ангийн 36 хүүхэд, Үндэсний бөхийн барилдаанд 3 ангиллаар 105 хүүхэд хүч чадал, авхаалж самбаагаа дайчлан барилдлаа. Тэмцээнийг Д.Лхачинсүрэн агсны үр хүүхдүүд, 1983 оны С.Шижирбаатар багштай 8а, 2013 оны Л.Оюунбилэг багштай 11б ангийн хамт олон сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулав.

“Дуулах цаг дуун цэнгүүн” арга хэмжээ явагдан 120 ахмад настныг хамруулж, “Эмэгтэйчүүдийн бүтээлч цаг” арга хэмжээний хүрээнд Баруунхараа САА-н “Охидын салаа”-ны ахмад тариаланчдыг алдаршуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж 85 ахмад настан хамрагдлаа.

Атрын 60 жилийг угтан “Тариаланчдаа алдаршуулсан дурсамж, дурдатгал” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд Монгол улсын гавьяат агрономч Д.Түмэнбаяр агсаны нэрэмжит “Алтан намар-2019” дууны уралдаан, ЕБС-ийн суралцагчдын дунд “Намрын аялгуу” дууны уралдаан, Ж.Лувсандоржийн нэрэмжит “Улсын аварга хадлангийн салааныхан” уулзалт арга хэмжээ, нийтийн бүжиг зэрэг урлагийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Сумын эрүүл мэндийн төв амбулаториор нийт 561 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Хүлээн авах хэсгээр 306 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Одоогийн байдлаар жирэмсний хяналтанд 46 эх байгаа бөгөөд энэ сард шинээр 6 эх хяналтанд орж, жирэмсний эрт үеийн хяналт 92 хувьтай байна.

ЭМЯ-аас зарласан “Тэмбүүг устгая” аян хүрээнд “Тэмбүүгүй сум” болох уриан дор 168 иргэнийг ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн сорилд хамруулахад 6 өвчлөл илэрснийг эмчилгээнд хамруулж байна. Хөх умайн хавдар эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 287 эмэгтэй хамрагдахаас 117 эмэгтэй хамрагдаж 40,7 хувьтай байна.

Сумын хүн амын дундах шүдний өвчлөлийг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын Анхилам шүдний эмнэлгийн эмч Гүнчин-Иштэй гэрээ байгуулан 6 удаагийн үзлэгээр нийт 575 хүнд шүд авах, шүд хийх, шүдний өнгөц, дунд, гүн цооролыг эмчлэх, сувгийн эмчилгээ, шүдний чулуу түүх, шүд цайруулах эмчилгээ, шүдэнд шигтгээ наах, шүдний ёзоор дээр голонцор хийж шүд босгох, хүүхдийн шүдний цоорол зогсоох хар түрхлэг зэргийг хийж шүд цоорлоос урьдчилан сэргийлэх үзлэг хийж, шүдийг зөв угаах аргачлалыг зааж зөвлөгөө өгч ажиллаж байна.

Орхонтүүл сум

Сумын Засаг даргын Зөвлөл тайлант сард 2 удаа хэлэлцэж иргэдээс ирүүлсэн өргөдлүүд болон цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Тайлант сард иргэдээс нийт 2 өргөдөл хүсэлт ирүүлсэн байна. үүнээс ажил хүссэн 2 өргөдөл ирсэнийг шийдвэрлэж хариуг албан тоотоор хүргүүлээ.Жилийн эцэс болж байгаатай холбогдуулан төсвийн байгууллага,төрийн захиргааны ажилтнуудаас МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг биелэлт,Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтүүдийг авч нэгтгэн тайлан мэдээ хүргүүлэхэд бэлэн болоод байна .

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Архи үгүй амьдрал аз жаргалтай” аяныг сумын Засаг даргын 2019.08.28-ны өдрийн А101 тоот захирамжаар зохион байгуулж байна. Аяны хүрээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд хяналт шалгалт хийх болон мэдээлэл сурталчилгааны ажлууд зохион байгуулагдаж байна.

Энэ сард шинээр төрөлт-7 эцэг тогтоолт-1 гэрлэлтийн бүртгэл-1 тус тус бүртгэгдсэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 7 хүүхэдэд хүндэтгэл үзүүлээ.Монгол улс бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 10 жилийн ой, сумдыг иргэний бүртгэлийн мэдээллийн цахим санд холбосонтой холбогдуулан “Улсын бүртгэл-хөгжлийн тулгуур” сэдвийн хүрээнд иргэдэд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх санал хүсэлтийг сонсох, салбарын ололт амжилтыг олон нийтэд сурталчлах зорилгоор энэ сарын 14-нд Сайхан суманд болсон “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээгээр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга болон холбогдох мэргэжилтнүүд хүрэлцэн ирж цахим үнэмлэх, гадаад паспорт, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн гэрчилгээг шийдвэрлэж иргэдэд зохих үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Манай сумаас уг арга хэмжээнд хамрагдсан 3 иргэний хаясан гэсэн цахим үнэмлэх, 2 иргэний худалдах

худалдан авах гэрээгээр орон сууцны гэрчилгээг газар дээр нь шийдвэрлэж гэрчилгээг хэвлэн иргэнд олголоо

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 11-р сарын 28-ны байдлаар 5671.4 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 12 даатгуулагчаас 765.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулан шинээр малчин 2, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 2 иргэнийг тус тус хамруулан даатгуулагчдаас 3999.3 мянган төгрөгийн орлого орууллаа.

“Даатгуулагч танд урьдчилан зөвлөө- тусалъя” аяны хүрээнд 2019-2020 онд тэтгэвэр тогтоолгох иргэдийн судалгааг гарган 5 даатгуулагчдад зөвлөмжийн хуудас өгч зөвөлгөө мэдээлэл өгч ажиллалаа.

ЕБС-иудын 5-11 дүгээр ангийн сурагчдын дунд “Атрын 60 жил” гар зургийн уралдааныг зарлаж, Рашаант тосгоны ЕБС-ийн сурагчдын ирүүлсэн бүтээлүүд шалгарч, шагнаж урамшуулсан.

Сумын ИТХ-аас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээнд төр төсвийн албан хаагчдын хамт албан иргэдэд үйлчилгээ үзүүллээ.

Рашаант тосгонд төрийн өмчийн 75 хүүхдийн ортой цэцэрлэг баригдаж ашиглалтанд орохтой холбогдуулан сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн баримт материалыг бүрдүүлэн аймгийн засаг даргын нийгмийн бодлогын хэлтэст хүргүүллээ.

Атар газар нээгдсэний түүхт 60 жилийн ойг угтан зохион байгуулах арга хэмжээний хүрээнд “Атар газар арвай буудай” уриатай хүмүүнлэгийн аяны ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Улсын Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 10-р сарын 04-ны өдрийн 01/1046 тоот албан даалгаврын дагуу Улсын 2020 оны хэрэгцээт махны нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд Мал эмнэлэгийн тасаг болон Мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжийн эмч нар малчидтай хамтран сумын хэмжээнд 26 малчдын 427 толгой мал махан бүтээгддэхүүнийг Улаанбаатар хотын хэрэгчлэгчдэд борлуулсан. 11сард 388 хонь,33 адуу,79 үхэр,59 ямаа нийт 559 толгой малын мах махан бүтээгдэхүүн зах зээлд борлуулаад байна.Сумын хэмжээнд мал эмнэлэгийн үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуй нэгж-д хяналт шалгалт хийн тайлан мэдээг аймгийн мал эмнэлэгийн газарт хүргүүлээд байна.

ХХААХҮС-ын 2019 оны 21-ний өдрийн 466 тоот албан даалгаврын дагуу бэлчээрийн ургамалд нөхөөл учруулж байгаа үлийн цагаан оготной тэмцэх ажлыг байгаль орчинд халгүй энгийн механик,биологийн аргаар малчид болон иргэд тариаланчидад хамтран 8000 га талбайд устгал хийж тайлан мэдээг хүргүүллээ.

Сүхбаатар сум

Хүүхэд хамгааллын 2019 оны нэгтгэсэн судалгааг гарган программд шивж орууллаа.

11-р сард 2,3,4-р багт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын кейс гарч ажиллаж байна. 3-р багийн Хамтарсан багт Сонгинохайрхан дүүргийн хамтарсан баг ирж туршлага солилцох уулзалт хийлээ. Мөн үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 3 хүүхдийн асуудлыг Сумын хамтарсан баг хуралдан мэргэжлийн эмч, цагдаагийн ажилтан багийн Хамтарсан баг хамтран хуралдаж эмчилгээ үйлчилгээний зардал, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулан өвлийн хувцас дэмжлэг үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор Биеийн тамир, спортын тухай хууль, “Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ 2005:5538 стандартаар батлагдсан “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд ЗДТГ, Сургууль, Цэцэрлэгийн багш, ажилчид, хүүхдүүднийг 3653 хүнээс авч, “Сорилын нэгдсэн программ”-д шивж, тайланг аймгийн Биеийн тамир, мпортын газарт хүргүүллээ.

“Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЭМГ-аас “Нөлөөллийн сургалт, уулзалт”-ыг зохион байгууллаа. Сургалт, уулзалтанд тус сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч, Цагдаагийн хэсгийн байцаагч, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нийт 43 хүн хамрагдлаа. Сүхбаатар суманд сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг оношлогоо зохион байгуулахаар төлөвлөгдөөд байна.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 573 тоот албан бичгийн дагуу Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас “Эрүүл мэндийг дэмжихэд настны оролцоо” сэдэвт настанд зориулсан сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл өдөр бүр 3 цагийн сургалтыг зохион байгуулж байна. Сургалтанд 400 гаруй ахмад настан хамрагдаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан спортын тэмцээн, уралдааныг 2019 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Ерөнхий боловсролын 3-р сургуулийн спорт заланд зохион байгууллаа. Тэмцээнд 8 багийн 80 гаруй тамирчид хурд хүч, оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Сумын Засаг даргын захирамжаар сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулан зээлдэгч нартай уулзаж мэдүүлэх хуудсыг өгч, барагдуулах талаар сануулга өгч ажиллалаа.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан “Өөрийгөө хөгжүүлэхүй” сургалтанд 40 аж ахуйн нэгж, иргэдийг төлөөллийг оролцууллаа. Мөн “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” зорилтын дор давсны зохистой хэрэглээг хэвшүүлэх, иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давс багатай хоол, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяныг 7 сургууль, 6 цэцэрлэг, 30 нийтийн хоол үйлдвэрлэгчдийн дунд зохион байгуулсан тухай ажлын тайланг ХХААГ-т хүргүүлээ.

Утсан загасны худалдаа эрхлэгчдэд хууль сахин мөрдүүлэх ажлын хүрээнд зөвшөөрөгдсөн, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд, баталгаатай хэмжих хэрэгслээр худалдаа хийх тухай захирамж гаргаж, хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/274 дугаар захирамж, сумын Засаг даргын А/256 дугаар захирамжийн дагуу Сумын хэмжээнд үржилд ашиглаж байгаа цөм сүргийн малыг ялган тэмдэглэх бүртгэлжүүлэлтэнд 36 өрхийн 422 толгой үхрийг ялган тэмдэглэн ээмэгжүүлж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж авлаа.

Монгол Улсын Ойн тухайн хуулийн 17.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 20-ны 86 тоот тогтоолыг үндэслэн, Сүхбаатар сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний модоор хангах гэрээг, Алтанбулаг, Түшиг, Ерөө, сумуудтай 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд Түшиг сумаас 15000 шоо метр, Ерөө сумаас 6500 шоо метр, Алтанбулаг сумаас 6500 шоо метр түлшний модыг тухайн сумуудын нутаг дэвсгэрээс нийлүүлэхээр гэрээ байгуулснаар, гэрээний дагуу Алтанбулаг сумын нутаг дэвсгэрээс 2019 оны 11 дүгээр сарын 10 өдрөөс тус сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний мод олгож эхлээд байна. Одоогийн байдлаар Алтанбулаг сумаас 129-н иргэнд 645 м³ түлшний мод өгч эхлээд байна.

Сүхбаатар суманд 1 мөрөн, 2 гол, 1 булаг байдаг. Шар хөвийн булгийн хамгаалалтын чулуун хашааг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын зөрчил гаргасан 2 иргэнийг дайчилж, 2 портер хашаа, хаалт хийх хавтгай чулуу буулгуулж булгийн эхийг хамгаалж ажиллалаа.

Хушаат сүм:

Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойгоор Хушаат сумын ЗДТГ-ын ХААТ-ийн дарга, агрономич Т.Баасандорж "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор, "Өгөөж мандал уул" ХХК-ий тариаланч С.Наадам, Г.Энхбаяр нар "Алтан

гадас" одонгоор тус тус шагнагдлаа. Ойн хүрээнд зарласан "Атар-60" болзолт уралдаанд "Төмс, хүнсний ногоо тариалагч аж ахуйн нэгж" номинацид тус сумын "Элит үр" ХХК-ий хамт олон 1-р байр эзэлж, "1000 га-гаас дээш талбайд үр тариа тариалсан аж ахуйн нэгж" номинацид "Өгөөж мандал Уул" ХХК-ий хамт олон 2-р байр эзэллээ.

Мөн ойн арга хэмжээний хүрээнд Атарын 1,2-р аянд ажиллаж явсан ахмад тариаланч М.Эрхэмбаяр, Д.Загдаахүү, Н.Даш, Д.Рэнцэнханд, Р.Шагдар, С.Лхагвасүрэн, Х.Намсрайжав, Х.Шуурай, П.Тогоо, Ө.Гаадай, Д.Гомбо, Л.Дондог, Отгонжаргал, Долгор нарын дурсамж яриаг гэрэл зургийн хамт сумын "Нээлттэй Хушаат" цахим хуудас, Fb хуудсаар дамжуулан олны хүртээл болгосон.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор "Шинэ Үндсэн хууль батлагдсан өдөр"-т зориулан шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 10 жил, Улсын бүртгэлийн ажилтны өдрийг тохиолдуулан бүртгэлийн байгууллагы нүүсэл хөгжил, түүхэн замнал, өнөөгийн бүртгэлийн үйл ажиллагаа, чиг хандлагыг сурталчлан зурагт үзэсгэлэн бэлтгэж ЕБС-ийн багш сурагчдад мэдээлэл хийсэн. Энэ үеэр иргэний үнэмлэхээ гардан авсан сурагчид иргэний андгай өргөв.

Аймгийн эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж буй "Өөдлөн дэвжих цаг" чуулганыг Хушаат сумад зохион байгуулж, сумын Эмэгтэйчүүдийн холбооныхон тайлангаа тавьсан. 2014-2019 онд ажилласан холбооны баг хамт олны ажлыг дүгнэж, эмэгтэйчүүдийн холбоог шинэчиллээ. Эмэгтэйчүүдийн чуулганы үеэр цагаан идээ, шинэ ургацын ногооны "Хушаатад үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.

Сумын статистикийн тайлан, мэдээ, судалгааг Засаг Даргын захирамжаар батлагдсан цаглабрын дагуу гаргадаг судалгааг цаг хугацаанд нь мэдээ, судалгааг гаргуулж аймагт мэдээллэж ажиллаж байна. Сумын хэмжээнд нийт 28632 төл гарсанаас /унага 728, тугал 3316, хурга 15046, ишиг 9542/ үүнээс 6 унага, 20 тугал, 50 хурга, 51 ишиг хорогдож 28505 төл эсэн мэнд бойжиж байна. Сумын хэмжээнд нийт 294 мал зүй бусаар хорогдсон /адуу 12, үхэр 57, хонь 105, ямаа 120/. Сумын хэмжээний 28 ААН, 72 иргэний хураасан, ургацын мэдээний байдлаар: Буудай - 8438 га талбайгаас 13739 тн ургац, Овьёос - 94 га талбайгаас 124 тн ургац, Тосны ургамал /рапс/- 2149 га талбайгаас 1514 тн ургац, Төмс – 245,1 га талбайгаас 3574,5 тн ургац, Хүнсний ногоо – 237,7 га талбайгаас 2498,6 тн ургац, Байцаа-4 га талбайгаас 72 тн ургац, Лууван-132,6 га талбайгаас 1380 тн ургац, Шар манжин-14,8 га талбайгаас 157 тн, Хүрэн манжин-12,5 га талбайгаас 127 тн, Өргөст хэмх-1,3 га талбайгаас 20 тн, Улаан лооль-0,5 га талбайгаас 6 тн, Тарвас-0,3 га талбайгаас 5 тн, Сонгино-72 га талбайгаас 730 тн ургац, Сармис-0,2 га талбайгаас 1,6 тн ургац

Сумын Эрүүл мэндийн төвд тайлант сард ор хоног 75, эмнэлэгт хэвтсэн 15, эмнэлгээс гарсан 7, злэгийн тоо бүгд 90, амбулатори 50, урьдчилан сэргийлэх 20, идэвхитэй хяналт 12, гэрийн идэвхитэй үзлэг 8, хяналтанд байгаа жирэмсэн 11, шинээр хяналтанд орсон 1, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 165, А-амин дэм уусан хүүхэд 165, түргэн тусламжийн дуудлага 45, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 20, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 20, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 31, шинжилгээнд хамрагдсан хүний тоо 42, элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 20 хийгдсэн.

Цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт 11-р сарын 01-ээс 11-р сарын 30-ны байдлаар хамран сургалт нийт 1817 хүүхэд хүлээн авахаас 1365 хүүхэд авч ирц 75 хувьтай байна. 2019-2020 оны хичээлийн жилийнсайжруулсан хөтөлбөрийг боловсруулж хүүхдийг сургуульд бэлтгэх нас насны онцлог хөгжлийг дэмжих 5 чиглэлээр сургалтыг зохион байгуулж ахлах, бэлтгэл, дунд, бага бүлгүүдэд "Хоол хүнс" сэдвийн хүрээнд зориудын болон зориудын бус хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн явуулж байна.

Атар газар үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойг угтаж багш, эцэг эх, хүүхдүүдийн дунд “Баян намар” өдөрлөг зохион байгуулж бүлгийн багш, хүүхдүүд бүтээлийн үзэсгэлэн гарган, эцэг эхчүүд ногоо болон цагаан идээний үзэсгэлэнг тус тус гарган идэвхитэй оролцлоо. Өдөрлөгийг дүгнэхэд 1-р байр С.Чулуунцэцэг багштай “Бэлтгэл” бүлэг, 2-р байр Р.Мартбаяр багштай “Ахлах” бүлэг тус тус эзэлсэн.

Аймгийн БСУГ-ын хуваарийн дагуу Мандал сумын Улсын тэргүүний “Нархан” цэцэрлэгтэй шефийн холбоо тогтоож, 11-р сарын 8-нд бүх багш, ажилчид ажил төрлийн туршлага судлах арга хэмжээнд оролцож хичээл үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаатай танилцлаа

Сургуулийн их засвар дуусч “Хүүхдийн хөгжил-сургалтын орчин” нээлтийн үйл ажиллагааг хийлээ.Нээлтэнд УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат оролцлоо. Энэ үеэр ахмад багш Б.Тулга, сургалтын менежер Г.Оюунцогзолмаа нар хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан. Багш, сурагчдын нэгдсэн концерт тус тус зохион байгууллаа.

Мөн бүх багш, ажилчдыг анхан шатны “Эрүүл мэндийн нэгдсэн үзлэг”-т хамруулж, судалгаа гарган аймагруу тайлан явуулсан.Мэргэжлийн бүх багш нарын дунд илтгэлийн уралдаан явуулсан. “Эцэг эхийн өдөрлөг” зохион байгууллаа.

Хүдэр сум:

Сумын хэмжээнд 6055 га талбайд улаан буудай, рапс 900 га, арвай 107 га, овьёос 206га, төмс 61 га, хүнсний ногоо 41 га тариалалт хийснээс улаан буудай 6055 га-гаас 6915 тонн, тэжээлд шилжсэн 400 га-гаас 360 тонн, арвай 107 га-гаас 190 тонн, овьёос 206 га-гаас 359 тонн, рапс 900 га-гаас 450 тонн, төмс 61 га-гаас 1250 тонн, хүнсний ногоо 41 га-гаас 465 тонн тус тус хураан авлаа.

Сумын хэмжээнд өвс бэлтгэх ажилд иргэд, малчид 3500 тонн өвс, аж ахуйн нэгж, байгууллага 2000 тонн өвс, нийт 5500 тонн бэлтгээд байна.

2019 онд Худалдаа үйлчилгээ эрхэлдэг бүх иргэдийг эрүүл мэндийн үзлэг хамруулж эрүүл мэндийн дэвтэр бүх худалдаа үйлчилгээний худалдагч нар олгуулж ажиллаа.Хяналтын албанаас ажлын байранд тавигдах шаардлагын дагуу санал хүсэлтийн дэвтэр, хөргөгчний температур үзэх дэвтэр, хугацаа хэтэрсэн барааны лангуу, буцаалтын дэвтэр, худалдагч нарыг энгэрийн тэмдэг, дүрэмт хувьцастай, өрөлт хураалтын стандартын дагуу болгож хэвшлээ.

Бог малын ашиг шим, малын чанарыг сайжруулах талаар Сумын ИТХ-аас 5,000,000 төгрөг баталж өгсний дагуу Төв аймгийн Жаргалант сумаас үзэмчин үүлдэрийн 14 хээлтүүлэгчийг авч сумын 14 малчин өрхөд тараан өгсөн. Хээлтүүлэгчийн нэг бүрийн үнэ 357,000 худалдан авсан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны “Нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагааг дэмжих” зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээгээр нийлүүлэх бүтээгдэхүүнийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, чанартай гүйцэтгэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. Хууль бус алт, ан агнуурын хяналт хийж морин эргүүл хийж баруун,зүүн Моностой, Батмөнгөлөгийн гол Нуурын тагт зэрэг газруудаар эргүүл шалгалт хийсэн. Шалгалтаар иргэн Ц-г хууль бус алт олборлож байхад нь илрүүлж техник хэрэгсэл болох ЗИЛ-131 машин-2 ширхэг, төхөөрөмж-1 ширхэг,тог үүсгэгч-1 ширхэгийг хурааж цагдаагийн хашаанд байрлуулсан.Ард иргэдэд Ойн тухай хууль сурталчилж 20-н иргэнд санамж бичиг тарааж ухуулан танилцуулж ажилсан.

Монгол Улсын Засгийн газрын баталсан 151-р журмын хэрэгжилт, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн үйл ажиллагаанд нийт 8 удаагийн хяналт шалгалтыг хийлээ. Хяналт шалгалтын явцад сумын Засаг даргатай үйл ажиллагаа явуулах гэрээ /бичил уурхайгаар ашигт малтмал олборлох/ байгуулсан 9 нөхөрлөлийн бичиг баримтыг шалгаж үзэхэд холбогдох хууль журмыг зөрчиж гэрээ

байгуулсан зөрчил илэрсэнийг тухайн нөхөрлөл, албан тушаалтанд мэдэгдэн гэрээг цуцлуулах арга хэмжээ авч ажиллаа. Нуурын тагт нэртэй бичил уурхайгаар олборлолт явуулж байсан “Нуурын тагт”, “Галуугийн булан” нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож албадан буулгасан. Шоргоолж нэртэй газар зохих зөвшөөрөлгүй олборлолт явуулсан “Маралз” ХХК-н зөрчлийн тухай хуулиар 10 сая төгрөгийн арга хэмжээ авч барагдуулан зөрчлийг арилгуулсан. Мөн Хүдэр голын эхэнд алт олборлож байсан нөхөрлөл, иргэдтэй холбогдох хууль журмыг зөрчихгүй гол ус бохирдуулахгүй байх талаар хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж урьдчилан сэргийлэх ажлыг хийж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-аас тус суманд ахуйн зориулалтаар 6 зэрлэг гахай, 4 бор гөрөөс, 100 кг загасны зөвшөөрөл ирснийг ан агнах хүсэлт гаргасан иргэдэд хуваарилан олгосон.

Аймгийн Засаг даргын А/367 тоот захирамжаар байгуулагдсан Улсын төсөв болон, орон нутгийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах ажлын хэсэгтэй хамтран Хүдэр сумын ойн санг гэрээгээр эзэмшдэг 15 ААНэгж, нөхөрлөлийн 198 га талбайн өөрийн хөрөнгийн ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь тооллого явуулж, талбайг хэмжиж хүлээж авлаа.

Улаанбаатар хотод 11 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлж, ойн доройтлыг бууруулах нь” сэдэвт сургалтанд Ойн ангийн дарга Г.Тайванбаатар оролцсон.

Сумын Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор түлээний мод бэлтгүүлэх захирамж гарсантай холбогдуулан сумын иргэдийн түлээний мод бэлтгэх газрын талбай тусгаарлалтыг Шийр ам, Шанд нэртэй газруудад хийсэн 2019 оны 11-р сарын 18-ны байдлаар түлээний мод бэлтгэлийн ажил 78 хувьтай байна. 2019 оны 11 дүгээр сарын 14-15 ны хооронд Засаг даргын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөөгийн малчидаар явж өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг 8 айлд олгож 160,000 төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн.

Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүр дээр биелүүлэх тал дээр анхааран ажиллаж байна. Дээд байгууллагаас ирүүлсэн хугацаатай бичиг, хийж гүйцэтгэх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж ажиллав. Цагдаагийн албан хаагч нартай хамтран Галт зэвсгийн албан татвар төлөгч 8 иргэнээс 480,0 мян.төгрөгийг хурааж төсөвт төвлөрүүлсэн. Өртэй аж ахуй нэгжүүдэд албан мэдэгдэл хүргүүлж ажиллаж байна. Татварын орлогын төрөл тасарч байгаа Галт зэвсгийн албан татвар, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын төлөвлөгөөг биелүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.

Сурагчдын авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болсон “Урлагийн бага наадам”-ыг 11-р сарын 16-нд 2-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Наадмын дүнгээр:

Дунд, ахлах анги :

- 1-р байр Д.Атарчимэг багштай 12б анги
- 2-р байр Ц.Отгонбаяр багштай 12а анги
- 3-р байр Ч.Түмэнжаргал багштай 9а анги

Бага анги:

- 1-р байр М.Энхтүвшин багштай 4а анги
- 2-р байр Н.Эрдэнэ багштай 5а анги
- 3-р байр Ш.Ариунаа багштай 5б ангиуд шалгарлаа.

“Дэлхийн зөн” Олон Улсын байгууллага, аймаг, орон нутгийн санхүүжилтээр ЕБСургуулийн ариун цэврийн байгууламжийг 98,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж дууссан. Уг байгууламж ашиглалтанд орсноор ЕБСургуулийн багш, сурагчид эрүүл ахуйн шаардагад нийцсэн орчинд сурч боловсрох боломжтой болж байна. Мөн сум, орон нутгийн хөрөнгө оруулалтын 18,0 сая төгрөгийн тендер зарлагдаж “Эрхэт рай” компани шалгарч “Англи хэлний лингафон” кабинетийг тохижуулан хүлээлгэн өгөөд байна.

Сургуулийн өмнөх байгууллагын сургалтын эрхлэх нөхцөл шаардлагын дагуу 2019-2020 оны хичээлийн жилд сумын тойргийн 2-6 хүртэлх насны нийт 261 хүүхдүүдээс 243 хүүхэд үндсэн сургалтанд хамрагдсан. 11-р сард 16 хоногт дундажаар 2748 ор хоногт, нэг өдөрт 171 хүүхэд өдөртэй 70 хувьтай хамран сургалтанд хамрагдаж байна.

Хүүхдийн эзэмших чадвар тус бүр хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн гурван түвшингээр олгож байна. 2-5 насны хүүхдийн хөгжлийн түвшинд өглөөнөөс орой хүртэл өдрийн дэглэмийн дагуу үйл ажиллагаагаар, хичээлийн цагийг өдөрт 1 цагаар төлөвлөж 128 цагийн хичээл хэвийн явагдаж ирлээ. Хүүхдийн хөгжлийн үнэлгээний хуудсыг уншиж судлах агуулгыг сонгох, төлөвлөх, боловсруулахад туслах, хүүхдийн тоогоор хэвлэх, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 7 хоногийн 1 өдөр 8 багшийн өглөөнөөс орой хүртэлх үйл ажиллагаа, хичээл төлөвлөлт дээр зөвлөмж өгч батлаж, 8 багшийн хичээлийн 128 цагийн төлөвлөлт үзэж хянаж ажиллаж байна. Багш нартай өдрийн үйл ажиллагаа, хичээл зохион байгуулах явцад зарим багш нартай ганцаарчилсан зөвлөгөө өгч хамтран ажиллаад байна.

2019-2020 оны хичээлийн жилд бүх цэцэрлэгт хамрагдах хүүхдүүдийн эрүүл мэндийг хянах картын дагуу Сэлэнгэ аймгийн засаг дарга Ш.Оргилын санаачлагаар халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, хүн амын мэдээллийн цахим санг бүрдүүлэх цогц үзлэг оношлогоо хүүхдийн эмчид цэцэрлэгийн 243 хүүхдээс 178 хүүхэд хамрагдаж 76% хамрагдсан. Шүдний өвчлөлтэй 91 хүүхэд буюу нийт хүүхдийн 45% эзэлж байна.

Сумын эрүүл мэндийн төв хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж иргэдээс гомдол санал гаргалгүй ажиллаж байна. Тайлант сард 4 эх амаржсан байна үүнээс сэлэнгэ аймагт 4, эх амржсан байна. Жирэмсний хяналтад шинээр 6 эх хянагдсан ба 0-3 сартайдаа хяналтанд орсон байна. Жирэмсний хяналтанд нийт 37 эх хянагдаж байна.

Шинээр төрсөн 5 нярай, төрсөн эхийг гэрээр эргэлт хийж усанд тогтмол оруулах асаргаа, эрүүл ахуйн зөвлөгөөг тогтмол өгч байна. Сэлэнгэ аймагт жирэмсний хүндрэлтэй хаван даралт ихтэй жирэмсэн эх 2, эрхтэн тогтолцооны эмгэгтэй 2, болон ихэр жирэмсэн 1 эхийг тус бүрийг цаг алдалгүй яаралтай түргэн тусламжийн машинаар хүргэн өгч 4 эхийг эсэн мэнд амаржуулав

Саа өвчний эсрэг уудаг вакцинд 10, Тавт вакцинд 10, Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын вакцины 1-р тунд 5, Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын вакцины 2-р тунд 7, В.Гепатит "А" 1-р тунд 4, В.Гепатит "А" 2-р тунд 7, Саа өвчний эсрэг тарьдаг вакцинд 8, Хатгалгааны эсрэг вакцинд 6, 2-т вакцин I тунд 66, , 2-т вакцин II тунд 33 иргэн тус тус хамрагдсан байна.

Тархвар судлалын заалтаар хийгдсэн дархлаажуулалтанд улирлын томуугийн вакцинд 17 эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнг дархлаажуулалтад хамрууллаа. Мөн томуугийн вакцинд сайн дурын дархлаажуулалтын кабинетаар 30 хүнийг вакцинжууллаа.

Жавхлант сүм:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 5 удаа боллоо.

"Иргэнд хүрсэн-Төрийн үйлчилгээ" нээлттэй хаалганы өдөрлөг, "Иргэдээ сонсьё" уулзалт, Төрийн захиргааны жинхэнэ албаны шалгалтанд тэнцсэн албан хаагчдыг тангараг өргүүлэх талаар нийтэд танилцуулж, ЕБС-ийн сурагчид иргэний андгай, Өсвөрийн цагдаа бүлгэмийн сурагчид тангараг өргөн "Төрийн албан хаагчдын манлайлал" байгууллагуудын урлагийн мэндчилгээг хүргэлээ

Улс тунхагласны ой, төрийн албан хаагчдын баярыг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын дунд "Төрийн албан хаагчийн манлайлал" болзолт уралдаанд санхүүгийн алба тэргүүн байр, Байгаль орчны

алба 2-р байр эзэлсэн. Энэ үеэр хувь хүний хөгжил, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн манлайлай, харилцаа хандлага сэдвээр сургалт явууллаа.

“Дэлхийн зөн” Олон Улсын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс “Өрхийн хөгжил-90” хөтөлбөрт хамрагдсан 2 иргэнд иж бүрэн таван ханатай гэр олголоо.

Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сумын Засаг даргын Тамгын газар, ЕБ-ын сургууль хамтран “Сэлэнгэ аймгийн хүүхдийн өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудал” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандартын дагуу хүргэж байна. Энэ сард урьдчилан сэргийлэх үзлэг 172, амбулаториор 84, гэрийн идэвхитэй эргэлтээр 90, идэвхитэй хяналтаар 34 хүнд хүнд хийж, иргэдэд хөнгөлөлттэй жороор 44 иргэнд 520000 төгрөгийн өртөг бүхий эмээр үйлчилж зөвлөгөө өгч ажилласан.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш М.Золжаргал, бага боловсролын сургалтын менежер А.Оюунтуяа нар хамтран 1-р ангийн сурагчдийн Монгол хэлний хичээлийн “Эгшиг авиа” үсгийн явцын үнэлгээг хийж нийт эцэг эхчүүдэд тайлан тавьсан.

Жил бүр ЕБС-ийн багш нарын дунд зохион байгуулагддаг сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаан 2019-2020 оны хичээлийн жилд “Сурагчдын ялгаатай байдлыг сургалтанд харгалзах нь- үйл ажиллагаа үр дүн” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж ЕБС-ийн багш нар 5 баг болж оролцсоноос Монгол хэл бичгийн багш А.Цэцэгдарь (Англи хэлний багш Д.Байгалмаа, Математикийн багш О.Цолмонтуяа, НТБ-ын багш Т.Мөнхмаа, Физикийн багш Д.Оюунсүрэн) ахлагчтай баг тэргүүлж 1-р байр эзэлж Ерөө бүсийн илтгэлийн уралдаанд оролцох эрхээ авлаа.

“Сэлэнгэ нутгийн эмэгтэйчүүд” өөдлөн дэвжих цаг чуулган амжилттай болж Соёлын ажилчид, дугуйлангийн сурагчдын хамтарсан урлагийн тоглолт, үзэсгэлэн худалдаа, “Эртэч Монгол” зэрэг сэтгэлгээ хэлэлцүүлэг зэрэг төрөлжсөн арга хэмжээг сурталчлан хамтран ажиллалаа.

Монгол Улсад Атар газар эзэмшсэний 60-н жилийн ойг угтаж Ерөө суманд зохион байгуулагдсан Монгол Улсын ХАА-н ууган баатар Н.Бямбацогт агсаны нэрэмжит “Алтан намар-2019” аймгийн аварга шалгаруулах дууны тэмцээнд Соёлын төвийн хөгжмийн багш Б.Баттулга, ахмад ардын авьяастан МУТАА Ц.Баяртогтох, МУТАА Даваажав ардын авьяастан Б.Оюунбат, Уламбаяр нар амжилттай оролцон 1-р байранд ардын авьяастан Б.Оюунбат 3-р байранд хөгжмийн багш Б.Баттулга нар шалгарлаа.

Сумын Моностой 2-р багийн Цагаан даваа гэх газраас ойн цэвэрлэгээний журмаар нийт 28 иргэнд ойгоос түлээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоод байна.

“Хоггүй Монгол” аяны хүрээнд нийтийн эзэмшлийн 5 га талбай болон ногоон байгууламжийн 1 га талбайн хог хаягдлыг Бумбат 1-р баг, Моностой 2-р багийн иргэд цэвэрлэсэн.

Сумын Моностой 2-р багийн Жавхлант хайрхан, Жавхлант самбар, Баянхаруулын өвөр, хөдөөгийн зам дагуух бэлчээрийн талбай, Бумбат 1-р багийн Нарийн хүр, хогийн цэгийн орчим гэх мэт бэлчээрийн талбайн нийт 6000 га талбайд үлийн цагаан оготныг устгах ажлыг нийтийг хамарсан ажлаар хийж гүйцэтгэлээ

Сант сум

Намрын ургац хураалтын ажил дуусаж үр тариа, төмс, хүнсний ногоо, тосны ургамлын хураалт 100 хувьтай хангагдлаа. Үр тариа 1322 га талбайгаас 1486 тонн ургац хураан авч, 375 га талбай тэжээлд шилжиж 160 тонн ногоон тэжээл бэлтгэж, 1054 га талбай ургац алдсан байна. Төмс 260 га талбайгаас 3250 тонн ургац, хүнсний ногоо 84,5 га талбайгаас 1112,1 тонн ургац тус тус хураан авсан байна. 2019 онд 2295 га талбайд уриншийн боловсруулалт хийсэн байна.

Атрын 60 жилийн ойг суманд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тайлант сард “Атар 60” фото зургийн уралдаан, “Тариаланчид дуулж байна” цэнгүүн, гар бөмбөгийн тэмцээн арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа. Ойн баярын арга хэмжээг суманд 12 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр төвлөсөн байна.

Үлийн цагаан огтонотой байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлын хүрээнд сумын Засаг даргын А/121 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 5000 га талбайд утах болон ус цутгах аргаар огтоно устгалын ажлыг явууллаа. Тэмцэх ажлын техник үр дүн 85 хувьтай гэж дүгнэгдсэн байна. Бэлчээрийн мэрэгчидтэй тэмцэх нийтийг хамарсан ажилд 15 иргэнийг хөдөлмөрийн түр гэрээ байгуулан ажиллуулж ХЭДС-аас 2940000 төгрөгийн цалин урамшуулал олголоо.

Тайлант сард газрын харилцааны чиглэлээр сумын Засаг даргын 3 удаагийн шийдвэрээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 21 иргэнд 66,3 га газрыг олгоод байна. Мөн 2 ААНБ-ын 82,44 га газар, 23 иргэний 53,1 га газрын эзэмших эрхийг хүчингүй болгож, холбогдох мэдэгдэлийг хүргэж, дахин хуваарилахаар төлөвлөж байна.

Хүүхэд, өсвөр үеийнхэний дунд жүдо бөхийн спортыг хөгжүүлэх, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сумын ИТХ, ЗДТГ-аас Сант сумын уугуул Монгол Улсын спортын мастер Шуурайгийн Батболдын нэрэмжит жүдо бөхийн “Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд 14 багийн 320 гаруй тамирчин оролцлоо.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Гэмт хэрэг зөрчилгүй сум” аяныг зохион байгуулж ААНБ-уудаар “Аялах туг”-ийг аялуулж байна. Аяны хүрээнд сумын ЗДТГ-аас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжуудыг сурталчилан сургалт мэдээлэл, дэвжээ тэмцээн, шторкны уралдаан зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж хөдөөний 30 гаруй малчин өрх, ахлах ангийн 73 сурагч, 60 гаруй иргэд хамрагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Хүртээмжтэй ирээдүй” өдөрлөгийг зохион байгуулж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Улсын бүртгэлийн хуулийн шинэчилсэн найруулга, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоор сургалт мэдээлэл хийж 30 иргэн хамрагдлаа. Өдөрлөг арга хэмжээний үеэр аймгийн аварга малчин Хушаат 2-р багийн иргэн Б.Сэнгэбаатар хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн тус бүрт 1 хонь хандивлаж сайн үйлсийн дэмжлэг үзүүлсэн байна.

“Дэлхийн Зөн” ОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөрөөс сумын иргэдэд “Эцэг эх байх нь галзуу хулганаар давхих мэт” эцэг эхчүүдийн сургалтыг зохион байгуулж, ЕБС-ын ахлах ангийн сурагчдад өсвөр үеийнхэн, охид хөвгүүдийн үерхэл нөхөрлөлийн талаар сонирхолтой лекц тавьсан. Сургалтад эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч 73 иргэн, ахлах ангийн 50 сурагч хамрагдлаа.

Цагааннуур сум:

Атрын 60 жилийн ойг угтан ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд наамал, гар зураг, эсээ бичлэгийн уралдаан зарлаж, сумын төвийн зам дагуу баярын мэндчилгээт самбаруудыг шинэчилж байрлуулаад байна. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг хуралдаж бэлтгэл ажлын болон баярын ажил арга хэмжээний хөтөлбөр төлөвлөгөө баяр тэмдэглэх өдрийг 12 дугаар сарын 13,14-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр төвлөлоо.

Төрийн албан хаагчдын “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж” нээлттэй мэдээллийг Даваа гариг бүр зохион байгуулж иргэд, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд танилцуулж хэвшээд байна.

Сумын удирдах ажилтны “Зөвлөлдөх уулзалт”-ыг 11 дүгээр сарын 18-нд зохион байгуулж, байгууллагын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн буюу хойшид хийх ажлынхаа талаар ярилцаж зөвлөлдлөө.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн чиглэлийн давуу Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье аяны дагуу хийгдсэн ажлын тайлан, Ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо, Эрүүл мэндийн төвийн бичиг баримт, хүсэлтийг бүрдүүлэн А/458 албан тоот гаргаж Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Эрүүл мэндийн төвөөс хэвтэн эмчлүүлэгчдэд, ЕБ-ын сургуулиас дотуур байрны хүүхдүүдэд давс, чихрийн хэрэглээг бууруулах талаар уриалга, зөвлөмжийг өгч, гарын авлага тараасан.

Сэлэнгэ аймгийн Стандарт хэмжилзүйн газраас 11 дүгээр сард манай суманд худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн ажлын байранд холбогдох стандартын дагуу ээлжит тохиролын үнэлгээ хийв. Тохиролын үнэлгээнд бар-2, хүнсний мухлаг 1, тус тус хамрагдав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах аяны хүрээнд 11-р сарын 20-ны өдөр хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлийг байгуулж, АХА хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, байр эзлүүлэн шалгаруулсан. Сургалтанд 45 иргэн оролцсон.

Улсын хэмжээнд явуулж буй “Ногоон паспорт” аяныг зохион байгуулж, өсвөр үе, хүүхэд багачууд эх дэлхий, байгаль орчинтойгоо зөв харилцах дадал хандлагад суралцаж, амьдарч буй орчин нөхцөлд эх дэлхийгээ хайрлах, эко байх талаар таниулан сурталчиллаа.

Монгол Улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 6 иргэний өмчилсэн газрын бүртгэлийг мэдээллийн санд суулган кадастрын зургаар хангаж 3 иргэнд 6946 м2 буюу 5556800 төгрөгийн үнэ бүхий газрыг өмчлүүлэхээр олгосон. Мөн албан конторын зориулалтаар Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн 0,4 га, “Нарийн шүрэн” ХХК-ий тариалангийн 59 га газрын гэрээ гэрчилгээг шинэчлэн улсын бүртгэлд мэдээллийг нь явуулан газар эзэмших гэрээ гэрчилгээ олгосон.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгчдийг зээлдэгч тус бүрээр гарган, хугацаа хэмэрсэн зээлүүдийн нөхцөл байдал цаашид авах арга хэмжээний талаар орон тооны бус зөвлөлүүд, ИТХ-д танилцууллаа. Орон тооны бус зөвлөлийн гишүүдтэй хамтран хугацаа хэтэрсэн зээлдэгч нэг бүртэй уулзан, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцож, барагдуулах талаар чиглэл өглөө.

Түшиг сум:

Сэлэнгэ аймгийн Түшиг сум 2019 оны 11 дүгээр сарын 17- ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон “Алтан гадас” одонгоор шагнуулж, аймагтаа анхны “Алтан гадас” одонт сум боллоо. Алтангадас одонг Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Үүрийнтуяа гардуулж, аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, аймгийн Засаг дарга Ш.Оргил, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр ёслолын арга хэмжээнд оролцсон. Мөн атар газар эзэмшсэний 60 жилийн ойн баяраар газар тариалангийн салбарт 40 гаруй жил ажилласан тус сумын иргэн С.Санжсүрэн “Гавъяат агрономич”-оор цол тэмдгээр шагнагдлаа.

Түшиг сумын түүхэнд тодоор бичигдэх Атрын анхны шан татсан газар болох “Өндөр улиасны өвөр” хэмээх газарт дурсгалын хөшөө босгож мөнхжүүлэх ёслолын арга хэмжээ боллоо. Арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр, Түшиг сумын ИТХ-ын дарга Н.Барамсай, Засаг дарга Ц.Отгонтүйн болон атрын анхдагч, тариаланчид, хүүхэд залуус оролцлоо.

Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготоно устгалыг 6000 га талбайд байгаль орчинд ээлтэй энгийн механик, биологийн наргаартэмцэх ажлыг, нийгмийн бодлого хөдөлмөр эрхлэлт болон малчид, малчдын бүлэг, хоршоотой хамтарч гүйцэтгэлээ. Энэхүү ажилд нийт 30 иргэн оролцож, 6 автомашин ажиллууллаа.

Улаанбаатар төмөр замын мод бэлтгэх үйлдвэрийн Буйлаастын аманд 20 га талбайд талбай тусгаарлалт хийж 200 м³ нарс модыг арчилгааны зориулалтаар бэлтгэх ажлын мод бэлтгэл, тээвэрлэлтэнд хяналт тавин ажиллалаа.

Байгаль орчин аялал жуулчилалын яам, аймгийн Байгаль орчин аялал жуулчилалын газар, Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх хууль бус мод бэлтгэхтэй тэмцэх хэлтэс, аймгийн бүсийн сум дундын ойн ангитай хамтарч “Шинэбадрах” ХХК, “Мойлт нуга” ХХК, Улаанбаатар төмөр замын мод бэлтгэх үйлдвэрийн 2019 онд мод бэлтгэсэн талбай, цэвэрлэсэн талбай, мод гүйцэтгэлд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж ажиллаа.

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар ясли бүлгийн насны онцлогт тохирсон тоглоом наадгай, мөн байгууллагын ажилчдын дундын сангийн хуримтлалаар 5 бүлэгт 1-р хоолны 130 ширхэг аягыг авсан. ЭМТ- тэй хамтарч байгууллагын нийт 21 багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжигээнд хамруулж ажиллаа. “Шүд, гар угаах аян”- ны хүрээнд дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд гар болон шүд угаах дарааллыг эмч Б.Баяртуяа туслах багш нартай хамтран зөв дадал хэвшил олгох ажлыг зохион байгуулж ажиллаа.

Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих судлагдахууны талаар БСУГ-аас авсан хөндлөнгийн үнэлгээг 11-р сарын 12-нд бага боловсролын 3-5 дугаар ангийн нийт давхардсан тоогоор 253 сурагч шалгагдаж, 52.9 хувийн гүйцэтгэлтэй, дунд, ахлах анги 15 төрлийн хичээлээр 434 сурагч шалгагдаж 8 түвшингийн үнэлгээгээр үнэлэхэд 56.2 хувийн гүйцэтгэлтэйгээр шалгагдлаа.

“Хөгжилд бидний оролцоо-2019” байгууллага сурталчлах аяны хүрээнд Монгол өв уламжиллаа дээдлэх иргэдийн үндэсний ухамсарыг дээшлүүлэх зорилготой “Монгол шагай наадгай” тэмцээнийг 3 үе шаттай зохион байгуулсан. ЕБС-ийн 11-р ангийн сурагчид, анги удирдсан багш нарын санаачлагаар “Түшигийн ирээдүй-Түшигийн хүүхдүүд”-сонинг гаргаж албан байгууллага, айл өрхүүдэд түгээж ажилласан.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА